

**Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт
хоорондын зөрүүг тайлагнах журам**

НЭГ. Нийтлэг зүйл

- 1.1. Энэхүү журам нь санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайланг бэлтгэх арга, аргачлалаар хангана.
- 1.2. Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан нь анхан шатны баримт, тооцоолол, ажлын баримтаар баталгаажиж, татварын албанд тайлагнасан аж ахуйн нэгжийн орлогын албан татварын ТТ-2 тайлангийн холбогдох дүнтэй нийцэж байх ёстой.
- 1.3. Санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулах хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн бүртгэл, тайлагналд энэ журам хамаарахгүй.
- 1.4. Тайлант хугацаанд хүлээн зөвшөөрсөн орлого, зардал, олз, гарз, хөрөнгө ба өр төлбөрийн ажил гүйлгээний тухайн тайлант хугацааны бус харин ирээдүйн тайлант хугацааны татвар ногдуулах орлогын дүнд нөлөө үзүүлэхээр байвал **балансын өр төлбөрийн аргыг** ашиглан хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрнө.

**ХОЁР. “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт
хоорондын зөрүүг зохицуулах тайлан”-г бэлтгэх**

- 2.1. “Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан” (цаашид “тайлан” гэх) нь А-Ё хэсгээс бүрдэнэ.
- 2.2. Тайлангийн 1-р мөрөнд аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланд толилуулсан татварын өмнөх ашгийн дүнг нэмэх утгатайгаар, харин алдагдлын дүнг сөрөг утгатайгаар оруулна. Тайлангийн А-Ё хэсгийг дараах байдлаар бэлтгэнэ.

А. Байнгын зөрүүгээр зохицуулагдах дүн

- 2.3. Байнгын зөрүүгээр зохицуулагдах А хэсэг нь нэмэгдүүлэх болон бууруулах утга гэсэн 2 хэсгээс бүрдэнэ.
- 2.4. **Байнгын зөрүүгийн нэмэгдүүлэх дүн** гэсэн хэсгийн 3-р мөрөнд санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийн дүнд багтсан боловч татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нийт дүнг оруулна. Энэ мөрийн дүн нь ААНОАТ-ын тайлангийн хавсралт мэдээнд тайлагнасан татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нийт дүнтэй тэнцүү байна.
- 2.5. Тайлангийн 4-р мөрөнд байнгын зөрүүгийн нэмэгдүүлэх бусад дүнгийн нийлбэрийг оруулна. Тухайлбал, харилцан хамаарал бүхий этгээдийн ажил гүйлгээнд хийсэн тохируулга гэх мэт.
- 2.6. **Байнгын зөрүүгийн бууруулах дүн** гэсэн хэсгийн 6-р мөрөнд санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийн дүнд багтсан боловч татварын хууль тогтоомжийн дагуу татвараас чөлөөлөгдөх орлогын нийт дүнг оруулна. Тухайлбал, Засгийн газрын бондын хүүгийн орлого гэх мэт. Энэ мөрийн дүн нь ААНОАТ-ын тайланд тайлагнасан татвараас чөлөөлөгдөх орлогын дүнтэй тэнцүү байна.

- 2.7. Тайлангийн 7-р мөрөнд тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын нийт дүнг оруулна. Тухайлбал, эрх борлуулсны, эрхийн шимтгэлийн, хүүгийн, ногдол ашгийн орлого гэх мэт. Энэ мөрийн дүн нь ААНОАТ-ын тайланд тайлагнасан тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлогын нийт дүнтэй тэнцүү байна.
- 2.8. Тайлангийн 8-р мөрөнд байнгын зөрүүгийн бусад бууруулах дүнгийн нийлбэрийг оруулна.
- 2.9. **Байнгын зөрүүгээр зохицуулагдсан дүн** гэсэн 9-р мөр нь санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийн дүн (мөр 1) дээр байнгын зөрүүгийн нэмэгдүүлэх утга (мөр 2)-ыг нэмж, бууруулах утга (мөр 5)-ыг хассан дүн байна.

Б. Түр зөрүүгээр зохицуулагдах дүн

- 2.10. Тайлангийн 10-р мөрөнд хөрөнгөтэй холбоотойгоор тайлант үед үүссэн түр зөрүүгийн дүнг оруулна. Татвар ногдох түр зөрүүг сөрөг утгаар, хасагдах түр зөрүүг эерэг утгаар оруулна. Хөрөнгийн дансны үнэ татварын сууриас их байгаа нөхцөлд татвар ногдох түр зөрүү, харин хөрөнгийн дансны үнэ татварын сууриас бага байгаа нөхцөлд хасагдах түр зөрүү үүснэ.
- 2.11. Тайлангийн 11-р мөрөнд өр төлбөртэй холбоотойгоор тайлант үед үүссэн түр зөрүүгийн дүнг оруулна. Татвар ногдох түр зөрүүг сөрөг утгаар, харин хасагдах түр зөрүүг эерэг утгаар оруулна. Өр төлбөрийн дансны үнэ татварын сууриас их байгаа нөхцөлд хасагдах түр зөрүү, харин төлбөрийн дансны үнэ татварын сууриас бага байгаа нөхцөлд татвар ногдох түр зөрүү үүснэ.
- 2.12. Тайлангийн 12-р мөрөнд хөрөнгө, өр төлбөртэй холбоотой үүссэн түр зөрүүгийн бусад дэлгэрэнгүй орлого буюу эздийн өмчид нөлөөлсөн залруулгын дүнг оруулна. Бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн татвар ногдох түр зөрүү нэмэгдсэн бол хасах, харин буурсан бол нэмэх утгатай байна. Харин хасагдах түр зөрүү буурсан бол хасах, өссөн бол нэмэх утгатай оруулна.
- 2.13. Тайлангийн 13-р мөрөнд түр зөрүүгээр зохицуулагдсан ашгийн дүнг гаргахдаа байнгын зөрүүгээр зохицуулагдсан дүн (мөр 9)-г хөрөнгө, өр төлбөртэй холбоотой үүссэн түр зөрүүгийн нэмэгдүүлсэн болон бууруулсан утгаар тохируулна.

В. Татварын тайлангаар гарсан алдагдлын тооцоолол

- 2.14. Тайлангийн 14-р мөрөнд татварын албаар баталгаажуулсан өмнөх жилүүдийн алдагдлаас ашиглагдаагүй үлдсэн дүнг тайлант хугацааны эхний үлдэгдэл болгон оруулна.
- 2.15. Тайлангийн 15-р мөрөнд ирээдүйд нөхөгдөхөөр хүлээгдэж буй тайлант хугацаанд шинээр үүссэн алдагдлын дүнг оруулна.
- 2.16. Тайлангийн 16-р мөрөнд тайлант хугацаанд өмнөх жилүүдийн баталгаажсан алдагдлаас шилжүүлэн тооцсон дүнг оруулна.
- 2.17. Тайлангийн 17-р мөрөнд татварын тайлангаар гарсан өмнөх жилүүдийн алдагдлаас хүчингүй болсон болон алдагдлын дүнг нэмэгдүүлэх дүнг оруулна. Хүчингүй болсон алдагдлын дүнг хасах утгаар, алдагдлын дүнг нэмэгдүүлэх дүнг нэмэх утгаар оруулна.
- 2.18. Татварын тайлангаар гарсан өмнөх жилүүдийн алдагдлын эцсийн үлдэгдэл буюу 18-р мөрийн дүн нь өмнөх жилүүдийн алдагдлын ашиглаагүй үлдсэн дүнгийн тайлант хугацааны эхний үлдэгдэл (мөр 15) дээр шинээр үүссэн алдагдлын дүн (мөр 16)-г нэмж, тайлант хугацаанд шилжүүлэн тооцсон алдагдал (мөр 17)-ыг хасаж, алдагдалд хийсэн залруулга (мөр 18)-аар тохируулсан дүн байна.

Г. Тайлант үеийн татварын зардлын тооцоолол

- 2.19. Байнгын болон түр зөрүүгээр зохицуулагдсан дүнд татварын хууль тогтоомжийн дагуух бусад тохируулгыг хийх замаар тайлант үеийн татварын зардлын тооцооллыг энэ хэсэгт харуулна.
- 2.20. Тайлангийн 19-р мөрөнд байнгын болон түр зөрүүгээр зохицуулагдсан ашгийн дүн (мөр 13)-г оруулах ба энэ нь ААНОАТ-ын тайланд тусгасан татвар ногдуулах орлогын дүнтэй тэнцүү байна.
- 2.21. Тайлангийн 20-р мөрөнд татварын хууль тогтоомжийн дагуу тооцсон сайн дурын даатгалын хураамжийн хэтрэлтийг оруулна.
- 2.22. Тайлангийн 21-р мөрөнд тайлант үед өмнөх жилүүдийн алдагдлаас шилжүүлэн тооцсон дүнг оруулна.
- 2.23. Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын дүн буюу тайлангийн 22-р мөрийн дүн нь байнгын болон түр зөрүүгээр зохицуулагдсан ашгийн дүн (мөр 19) дээр сайн дурын даатгалын хураамжийн хэтрэлтийн дүн (мөр 20)-г нэмж, өмнөх жилүүдийн алдагдлаас шилжүүлэн тооцсон дүн (мөр 21)-г хассантай тэнцүү байна. Мөн энэ дүн нь ААНОАТ-ын тайланд тусгасан нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын дүнтэй тэнцүү байна.
- 2.24. Тайлангийн 23-р мөрөнд нийтлэг хувь хэмжээгээр тооцоолж ногдуулсан татварын дүнг оруулах ба энэ дүн нь нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын дүн (мөр 22)-ээс ААНОАТ-ын хуульд заасан татварын хувь хэмжээгээр тооцоолсон дүн байна.
- 2.25. Тайлангийн 24-р мөрөнд хөнгөлөгдөх татварын дүнг оруулна.
- 2.26. Тайлангийн 25-р мөрөнд тусгай хувь хэмжээгээр төлбөл зохих татварын дүнг оруулна.
- 2.27. Тайлангийн 26-р мөрөнд төлбөл зохих татвараас хасч тооцогдоогүй гадаад улсад төлсөн албан татварын зардлын дүнг оруулна.
- 2.28. Тайлант үеийн татварын зардал буюу 27-р мөрийн дүн нь ногдуулсан татварын дүн (мөр 23) -ээс хөнгөлөгдөх татварын дүн (мөр 24)-г хасаж, тусгай хувь хэмжээгээр төлбөл зохих татварын дүн (мөр 25) ба төлбөл зохих татвараас хасч тооцогдоогүй гадаад улсад төлсөн албан татварын зардлын дүн (мөр 26) -г нэмсэн дүн байна.

Д. Хойшлогдсон татварын өр төлбөрийн тооцоолол

- 2.29. Хойшлогдсон татварын өр төлбөр (ХТӨТ)-ийг энэхүү журмын Хавсралт 3-ын 1.3.5-д заасан нөхцлөөс бусад тохиолдолд заавал хүлээн зөвшөөрөх ба энэ нь татвар ногдох түр зөрүүг татварын дундаж хувь хэмжээгээр үржүүлсэнтэй тэнцүү байна.
- 2.30. Тайлангийн 28-р мөрөнд ХТӨТ-ийн эхний үлдэгдлийг оруулах ба энэ нь санхүүгийн байдлын тайланд толилуулсан дүнтэй тэнцүү байна. Хэрэв хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн тайланд цэвэр дүнгээр толилуулсан бол уг дүнг гаргахад ашигласан ХТӨТ-ийн дүнг энэ тайлангийн 28-р мөрийн дүнд оруулна.
- 2.31. Тайлангийн 29-р мөрөнд татварын хувь өөрчлөгдсөнөөс ХТӨТ-ийн эхний үлдэгдэлд хийх залруулгыг оруулна. Хэрэв залруулгаар эхний үлдэгдэл нэмэгдсэн бол залруулах дүн эерэг утгатай, эхний үлдэгдэл буурсан бол залруулах дүн сөрөг утгатай байна.
- 2.32. Тайлангийн 30-р мөрөнд татвар ногдох түр зөрүүгийн дүнг татварын дундаж хувиар үржүүлж гаргасан дүнг оруулна.
- 2.33. Тайлангийн 31-р мөрөнд бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн хойшлогдсон татварын өр төлбөрийн дүнг оруулна. Хэрэв тайлант үед бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн ХТӨТ-ийг буцаасан бол буцаалтын дүнг сөрөг утгатай оруулна.
- 2.34. ХТӨТ-ийн тайлант хугацааны эцсийн үлдэгдэл (мөр 30) -ээс бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн хойшлогдсон татварын өр төлбөрийн дүн (мөр 31), ХТӨТ-ийн эхний үлдэгдэл (мөр 28), татварын хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас хийгдэх залруулга

(мөр 29)-ыг тус тус хассанаар тайлант хугацаанд татвар ногдуулах түр зөрүүтэй холбоотой нэмж хүлээн зөвшөөрөх хойшлогдсон татварын зардал эсхүл орлогын дүн (мөр 32)-г гаргана. Энэ мөрөнд тооцоолсон дүн эерэг утгатай бол хойшлогдсон татварын зардал, сөрөг утгатай бол хойшлогдсон татварын орлого үүснэ.

Е. Хойшлогдсон татварын хөрөнгийн тооцоолол

- 2.35. Хойшлогдсон татварын хөрөнгө (ХТХ)-ийг энэхүү журмын Хавсралт 3-ын 1.3.5-д заасан нөхцлөөс бусад тохиолдолоос гадна зөвхөн ирээдүйд нөхөгдөх боломжтой үед л хүлээн зөвшөөрнө.
- 2.36. Тайлангийн 33-р мөрөнд ХТХ-ийн эхний үлдэгдлийг оруулах ба энэ нь санхүүгийн байдлын тайланд толилуулсан дүнтэй тэнцүү байна. Хэрэв ХТХ ба ХТӨТ-ийг санхүүгийн тайланд цэвэр дүнгээр толилуулсан бол уг дүнг гаргахад ашигласан ХТХ-ийн дүнтэй энэ тайлангийн 33-р мөрийн дүн тэнцүү байна.
- 2.37. Тайлангийн 34-р мөрөнд татварын хувь өөрчлөгдсөнөөс ХТХ-ийн эхний үлдэгдэлд хийх залруулгыг оруулна. Хэрэв залруулгаар ХТХ нэмэгдсэн бол залруулах дүн эерэг утгатай, харин буурч буй бол сөрөг утгатай байна.
- 2.38. Тайлангийн 35-р мөрөнд хасагдах түр зөрүүгийн дүнг татварын дундаж хувиар үржүүлж гаргасан дүнг оруулна.
- 2.39. Тайлангийн 36-р мөрөнд аж ахуйн нэгжийн үнэлгээгээр нөхөгдөх боломжгүй гэж үзсэн ХТХ-ийн дүнг оруулна.
- 2.40. Тайлангийн 37-р мөрөнд татварын тайлангаар гарсан өмнөх жилүүдийн алдагдлын эцсийн үлдэгдлээс тооцсон ХТХ-ийн дүнг оруулах ба энэ нь татварын тайлангаарх өмнөх жилүүдийн алдагдлын эцсийн үлдэгдэл (мөр 18)-ийг татварын дундаж хувь хэмжээгээр үржүүлсэнтэй тэнцүү байна.
- 2.41. Тайлангийн 38-р мөрөнд ХТХ-ийн эцсийн үлдэгдлийг тооцоолж гаргах ба энэ нь хасагдах түр зөрүүгээс тооцоолсон ХТХ-ийн эцсийн үлдэгдэл (мөр 35)-ээс нөхөгдөх боломжгүй гэж үзсэн ХТХ-ийн дүн (мөр 36)-г хасаж, татварын тайлангаарх өмнөх жилүүдийн алдагдлын эцсийн үлдэгдлээс тооцсон ХТХ-ийн дүн (мөр 37)-г нэмсэн дүнтэй тэнцүү байна.
- 2.42. Тайлангийн 39-р мөрөнд бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн хойшлогдсон татварын хөрөнгийн дүнг оруулна. Хэрэв тайлант үед бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн хойшлогдсон татварын хөрөнгийг буцаасан бол буцаалтын дүнг сөрөг утгатай оруулна.
- 2.43. ХТХ-ийн эхний үлдэгдэл (мөр 33), татварын хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас хийгдэх залруулга (мөр 34), бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн хойшлогдсон татварын хөрөнгийн дүн (мөр 39)-ийн нийлбэрээс ХТХ-ийн тайлант хугацааны эцсийн үлдэгдэл (мөр 39)-ийг хассанаар тайлант хугацаанд хасагдах түр зөрүүтэй холбоотой нэмж хүлээн зөвшөөрөх хойшлогдсон татварын зардал эсхүл орлогын дүн (мөр 40)-г гаргана. Энэ мөрөнд тооцоолсон дүн эерэг утгатай бол хойшлогдсон татварын зардал, сөрөг утгатай бол хойшлогдсон татварын орлого үүснэ.

Ё. Татварын зардлын тооцоолол

- 2.44. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх орлогын албан татварын зардлын дүн нь тайлант үеийн ба хойшлогдсон татварын зардлын нийлбэртэй тэнцүү байна.
- 2.45. Хойшлогдсон татварын зардал нь татварын зардлыг нэмэгдүүлнэ. Харин хойшлогдсон татварын орлого нь татварын зардлыг бууруулна.

ГУРАВ. Түр зөрүүгийн тооцооллын бэлтгэх үлгэрчилсэн ажлын хүснэгт

- 3.1. Хөрөнгө, өр төлбөрийн түр зөрүүг тооцоолж, хойшлогдсон татварын хөрөнгө ба хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхөд **балансын өр төлбөрийн аргыг** ашиглана.

- 3.2. Хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн тайланд толилуулсан дансны үнэ, татварын суурийн зөрүүнээс түр зөрүү үүснэ. Гэвч түр зөрүү бүр нь хойшлогдсон татварын үр нөлөөтэй байдаггүй. Хавсралт 3-ын 1.3.5 дахь заалтыг үзнэ үү.
- 3.3. Түр зөрүү нь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах ирээдүйн тайлант үед татвар ногдуулах орлогыг нэмэгдүүлэх нөлөөлөл үзүүлж байвал түүнийг “Татвар ногдох түр зөрүү” гэнэ.
- 3.4. Түр зөрүү нь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах ирээдүйн тайлант үед татвар ногдуулах орлогыг бууруулах нөлөөлөл үзүүлж байвал түүнийг “Хасагдах түр зөрүү” гэнэ.
- 3.5. Хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ гэж СТОУС эсхүл ЖДААН-ийн СТОУС-ын дагуу тооцоолсон балансын өдрөөрх хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг хэлнэ. Энэ нь НББОУС 12 “Орлогын албан татвар”-аас бусад бүх стандартыг мөрдөж гаргасан дүн юм.
- 3.6. Хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь гэж татварын хууль тогтоомжийн шаардлагын дагуу тооцсон хөрөнгө буюу өр төлбөрийн дүнг хэлнэ.
- 3.7. Хөрөнгийн татварын суурь нь хөрөнгийн дансны үнийг нөхөх үед аж ахуйн нэгжид орох татвар ногдуулах эдийн засгийн өгөөжөөс татварын зорилгоор хасагдах дүн юм.
- 3.8. Өр төлбөрийн татварын суурь нь ирээдүйн тайлант үед уг өр төлбөртэй холбоотой татварын зорилгоор хасагдах дүнг хассан дансны үнэ юм.
- 3.9. Хөрөнгө, өр төлбөр тус бүрийн хувьд татварын суурь, дансны үнийн дэлгэрэнгүй бүртгэлийг доорх Хүснэгт 1-д тусгасан үлгэрчилсэн ажлын хүснэгтийг ашиглан тооцоолж болно.

Хүснэгт 1. Түр зөрүүг тооцоолох үлгэрчилсэн ажлын хүснэгт

№	Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлт	Дансны үнэ		Татварын суурь		Зөрүү		Түр зөрүүгээр хүлээн зөвшөөрөхгүй зөрүү		Түр зөрүү		Хүлээн зөвшөөрсөн түр зөрүүгийн тайлант үеийн өөрчлөлт*
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэг- дэл	Эцсийн үлдэг- дэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
		(1)	(2)	(3)	(4)	(5)=(1)-(3)	(6)=(2)-(4)	(7)	(8)	(9)=(5)-(7)	(10)=(6)-(8)	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө									-	-	-
2	Авлага									-	-	-
3	Бараа материал									-	-	-
4	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө									-	-	-
5	Үндсэн хөрөнгө									-	-	-
6	Биет бус хөрөнгө									-	-	-
7	Судалгаа, хөгжүүлэлтийн зардал									-	-	-
8	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө									-	-	-
9	Хөрөнгө оруулалт									-	-	-
10										-	-	-
11										-	-	-
12	Хөрөнгийн нийт дүн	-	-	-	-					-	-	-
13	Дансны өглөг									-	-	-
14	Баталгаат засварын нөөц									-	-	-
15	Бусад нөөц									-	-	-
16	Урт хугацаат зээл									-	-	-
17	Бусад өр төлбөр									-	-	-

18										-	-	-
19										-	-	-
20	Өр төлбөрийн нийт дүн	-	-	-	-					-	-	-
21	Хувь нийлүүлсэн хөрөнгө											
22	Халаасны хувьцаа											
23	Нэмж төлөгдсөн капитал											
24	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл											
25	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц											
26	Эздийн өмчийн бусад хэсэг											
27	Хуримтлагдсан ашиг											
29	Эздийн өмчийн дүн	-	-	-	-							
30	Өр төлбөр, эздийн өмчийн нийт дүн	-	-	-	-							

* 1) Хөрөнгийн хувьд: нэмэх утгатай гарвал татвар ногдох түр зөрүү, хасах утгатай гарвал хасагдах түр зөрүү гэж үзнэ.

2) Өр төлбөрийн хувьд: нэмэх утгатай гарвал хасагдах түр зөрүү, хасах утгатай гарвал татвар ногдох түр зөрүү гэж үзнэ.

- 3.10. Үлгэрчилсэн ажлын хүснэгтийн 1 ба 2-р багананд хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн зүйлсийн дансны үнийн эхний ба эцсийн үлдэгдлийг санхүүгийн байдлын тайлангаас оруулна. Эдгээр багана тус бүрийн хувьд нийт хөрөнгийн дүн (мөр 12) нь өр төлбөр, эздийн өмчийн дүн (мөр 30) -тэй тэнцүү байна.
- 3.11. Үлгэрчилсэн ажлын хүснэгтийн 3 ба 4-р багананд хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн зүйлсийн татварын суурийн эхний ба эцсийн үлдэгдлийг тооцоолж, оруулна. Эдгээр багана тус бүрийн хувьд нийт хөрөнгийн дүн (мөр 12) нь өр төлбөр, эздийн өмчийн дүн (мөр 30) -тэй тэнцүү байна.
- 3.12. Үлгэрчилсэн ажлын хүснэгтийг 5 ба 6-р баганад хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ ба татварын суурийн зөрүүг бодож оруулна.
- 3.13. Түр зөрүүг тооцоолох ажлын хүснэгтийн 7, 8-р багананд татвар ногдох эсвэл хасагдах түр зөрүү үүсгэхгүй зөрүүгийн дүнг тавина. Хавсралт 3-ийн 1.3.5 дахь заалтыг харна уу.
- 3.14. Түр зөрүүг тооцоолох ажлын хүснэгтийн 9-р багананд хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийн эхний үлдэгдлээс татварын суурийн эхний үлдэгдэл болон түр зөрүү үүсгэхгүй зөрүүгийн дүнг хасаж түр зөрүүгийн эхний үлдэгдлийг гаргана.
- 3.15. Түр зөрүүг тооцоолох ажлын хүснэгтийн 10-р багананд хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийн эцсийн үлдэгдлээс татварын суурийн эцсийн үлдэгдэл болон түр зөрүү үүсгэхгүй зөрүүгийн дүнг хасаж, түр зөрүүгийн эцсийн үлдэгдлийг гаргана. Энд гаргасан дүнг татварын дундаж хувь хэмжээгээр үржүүлэн хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн дансдын эцсийн үлдэгдлийг тооцоолно.
- 3.16. Түр зөрүүг тооцоолох ажлын хүснэгтийн 11-р багананд түр зөрүүгийн тайлант үеийн өөрчлөлтийг харуулах ба энэ нь түр зөрүүгийн эцсийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасаж гаргасан дүн байна. Энд гаргасан дүнг ашиглан түр зөрүүгээр зохицуулагдсан татвар ногдуулах орлогыг тооцоолно.

~ 00 0 00 ~

САНХҮҮГИЙН БОЛОН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ ХООРОНДЫН ЗӨРҮҮГ ЗОХИЦУУЛАХ ТАЙЛАН

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

	Үзүүлэлт	Мөр	Дүн
	Санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийн дүн	1	
А БАЙНГЫН ЗӨРҮҮГЭЭР ЗОХИЦУУЛАГДАХ ДҮН			
1	Байнгын зөрүүгийн нэмэгдүүлэх дүн (мөр 3+4)	2	
	Албан татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын дүн	3	
	Бусад байнгын зөрүүгийн нэмэгдүүлэх дүн	4	
2	Байнгын зөрүүгийн бууруулах дүн (мөр 6+7+8)	5	
	Татвараас чөлөөлөгдөх орлогын дүн	6	
	Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлогын дүн	7	
	Бусад байнгын зөрүүгийн бууруулах дүн	8	
	БАЙНГЫН ЗӨРҮҮГЭЭР ЗОХИЦУУЛАГДСАН ДҮН (мөр 1+2-5)	9	
Б ТҮР ЗӨРҮҮГЭЭР ЗОХИЦУУЛАГДАХ ДҮН			
	Хөрөнгөтэй холбоотойгоор тайлант үед үүссэн хасагдах түр зөрүү ба (татвар ногдох түр зөрүү)	10	
	Өр төлбөртэй холбоотойгоор тайлант үед үүссэн хасагдах түр зөрүү ба (татвар ногдох түр зөрүү)	11	
	Бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн татвар ногдох түр зөрүүг (нэмэгдүүлэх) бууруулах дүн ба хасагдах түр зөрүүг нэмэгдүүлэх (бууруулах) дүн	12	
	ТҮР ЗӨРҮҮГЭЭР ЗОХИЦУУЛАГДСАН ДҮН (мөр 9+10+11+12)	13	
В ТАТВАРЫН ТАЙЛАНГААР ГАРСАН АЛДАГДЛЫН ТООЦООЛОЛ			
	Өмнөх жилүүдийн татварын тайлангаар гарсан алдагдлын эхний үлдэгдэл	14	
	Ирээдүйд нөхөгдөхөөр хүлээгдэж буй тайлант хугацаанд шинээр үүссэн алдагдлын дүн	15	
	Тайлант хугацаанд өмнөх жилүүдийн алдагдлаас шилжүүлэн тооцсон дүн	16	
	Алдагдлыг (буцаах) эсвэл нэмэгдүүлэх залруулга	17	
	Татварын тайлангаар гарсан алдагдлын эцсийн үлдэгдэл (мөр 14+15-16+17)	18	
Г ТАЙЛАНТ ҮЕИЙН ТАТВАРЫН ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ			
	Байнгын болон түр зөрүүгээр зохицуулагдсан ашгийн дүн (мөр 13)	19	
	Сайн дурын даатгалын хураамжийн хэтрэлт	20	
	Шилжүүлсэн алдагдлын дүн (мөр 16)	21	
	Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын дүн (мөр 19+20-21)	22	
	Ногдуулсан татвар (мөр 22*ААНОАТ-ын хуульд заасан татварын хувь хэмжээ)	23	
	Хөнгөлөгдөх татварын дүн	24	
	Тусгай хувь хэмжээгээр төлбөл зохих татварын дүн	25	
	Төлөх татвараас хасч тооцуулаагүй гадаад улсад төлсөн татвар	26	
	Тайлант үеийн татварын зардал (мөр 23-24+25+26)	27	
Д ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ӨР ТӨЛБӨРИЙН ТООЦООЛОЛ			
	Хойшлогдсон татварын өр төлбөрийн эхний үлдэгдэл	28	
	Татварын хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас хойшлогдсон татварын өр төлбөрийг нэмэгдүүлэх (бууруулах) залруулга	29	
	Хойшлогдсон татварын өр төлбөрийн эцсийн үлдэгдэл (Татвар ногдох түр зөрүүгийн дүн*Татварын дундаж хувь хэмжээ)	30	
	Бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн хойшлогдсон татварын өр төлбөрийн дүн (буцаалт)	31	
	Татвар ногдуулах түр зөрүүтэй холбоотой тайлант хугацаанд хүлээн зөвшөөрөх хойшлогдсон татварын зардал (орлого) (мөр 30-31-29-28)	32	

Е ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ХӨРӨНГИЙН ТООЦООЛОЛ

	Хойшлогдсон татварын хөрөнгийн эхний үлдэгдэл	33	
	Татварын хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас хойшлогдсон татварын хөрөнгийг нэмэгдүүлэх (бууруулах) залруулга	34	
	Хойшлогдсон татварын хөрөнгийн тооцоолсон эцсийн үлдэгдэл (Хасагдах түр зөрүүгийн дүн*Татварын дундаж хувь)	35	
	Нөхөгдөх боломжгүй хойшлогдсон татварын хөрөнгийн дүн	36	
	Татварын тайлангаарх өмнөх жилүүдийн алдагдлын эцсийн үлдэгдлээс тооцсон хойшлогдсон татварын хөрөнгийн дүн (Мөр 18 * Татварын дундаж хувь хэмжээ)	37	
	Хойшлогдсон татварын хөрөнгийн эцсийн үлдэгдэл (мөр 35-36+37)	38	
	Бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн хойшлогдсон татварын хөрөнгийн дүн (буцаалт)	39	
	Хасагдах түр зөрүүтэй холбоотой тайлант хугацаанд хүлээн зөвшөөрөх хойшлогдсон татварын зардал, (орлого) (33+34+39-38)	40	

Ё ТАТВАРЫН ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ

	Орлогын дэлгэрэнгүй тайлан дахь татварын зардлын нийт дүн (мөр 42+43+44)	41	
	Үүнээс: Тайлант үеийн татварын зардал (мөр 26)	42	
	Түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон татварын зардал (орлого) (мөр 32+40)	43	
	Татварын хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас үүссэн хойшлогдсон татварын зардал (орлого) (мөр 29-34)	44	

Тайланг үнэн зөв гаргасан:

Дарга /Захирал/:

тэмдэг

Ерөнхий нягтлан бодогч:

20 оны сарын өдөр

**Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын
зөрүүг зохицуулах, нягтлан бодох бүртгэлд бүртгэх аргачлал**

НЭГ. Нийтлэг зүйл

- 1.1. Энэ журам нь тайлант үеийн болон хойшлогдсон татварын дүнг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлд тусгахад арга зүйн удирдамжаар хангах зорилготой.
- 1.2. Татварын түр зөрүүг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлд тусгахдаа НББОУС 12 “Орлогын албан татвар”, СТОУС-ын Тайлбар 23 “Орлогын татварын тодорхой бус байдал”, ЖДААН-ийн СТОУС-ын 29-р хэсэг “Орлогын албан татвар”-ыг тус тус мөрдөнө.
- 1.3. Хойшлогдсон татварыг тодорхойлохдоо дараах 10 алхмыг баримтална:
 - 1.3.1. Тайлант үеийн татварын зардлыг тооцоолох;
 - 1.3.2. Татварын хууль тогтоомжийн дагуу тайлант үеийн татварын өглөгийг тооцоолох;
 - 1.3.3. Хөрөнгө, өр төлбөрийн татварын суурийг тодорхойлох;
 - 1.3.4. Хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ ба татварын суурийн хоорондох түр зөрүүг тооцох;
 - 1.3.5. Түр зөрүүнээс хойшлогдсон татвар хүлээн зөвшөөрөхгүй байх дараах тусгай нөхцлүүдийг авч үзэх:
 - Гүүдвилыг анх хүлээн зөвшөөрөх үед;
 - Хөрөнгө, өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрсөн ажил гүйлгээ нь бизнесийн нэгдэл биш ба нягтлан бодох бүртгэлийн ашиг эсвэл татвар ногдуулах орлого (татварын тайлангийн алдагдал)-д нөлөө үзүүлэхгүй байх;
 - Тодорхой шалгуурыг хангасан нөхцөлд охин компани, салбар, хараат компани болон хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалт.
 - 1.3.6. Хасагдах түр зөрүү, татварын тайлангаар гарсан алдагдал болон татварын хөнгөлөлтийг нөхөгдөх боломжийг үнэлэх;
 - 1.3.7. Түр зөрүүг буцаах үед мөрдөхөөр хүлээгдэж буй татварын дундаж хувь хэмжээг тодорхойлж, хойшлогдсон татварыг тооцоолох;
 - 1.3.8. Хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрөх;
 - 1.3.9. Тайлант үеийн болон хойшлогдсон татварын толилуулга ба цэвэр дүнг гаргалтыг авч үзэх;
 - 1.3.10. Тайлант үеийн ба хойшлогдсон татварын задаргааг тодруулах.

ХОЁР. Тайлант үеийн татвар

- 2.1. Тайлант үеийн татварын зардал гэж тайлант үеийн татвар ногдуулах орлого (татварын тайлангаарх алдагдал)-д суурилан тооцсон зардлыг ойлгон.
- 2.2. Тайлант үеийн болон өмнөх үеийн төлөгдөөгүй татварыг өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

- 2.3. Төлсөн татвар нь татварын өр төлбөрөөс давсан байвал илүү төлсөн дүнг татварын авлагаар хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.
- 2.4. Тайлант үеийн татварын өглөг (авлага) -ийг хэмжихдээ тайлант үед хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хууль тогтоомжинд заасан татварын хувь хэмжээг мөрдөнө.

ГУРАВ. Татварын суурь ба дансны үнэ

- 3.1. Хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь ба дансны үнийн зөрүүг тооцоолж, хойшлогдсон татварын хөрөнгө ба хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхөд НББОУС 12 “Орлогын албан татвар”-д заасан **балансын өр төлбөрийн аргыг** ашиглана.
- 3.2. Балансын өр төлбөрийн аргаар хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ ба татварын сууринд үндэслэн татварын түр зөрүүг тооцоолж, бүртгэдэг.
- 3.3. Хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ гэж СТОУС эсхүл ЖДААН-ийн СТОУС-ын дагуу тооцоолсон балансын өдрөөрх хөрөнгө, өр төлбөрийн дансны үнийг хэлнэ. Энэ нь НББОУС 12-оос бусад бүх стандарт эсхүл ЖДААН-ийн СТОУС-ын 29-р хэсгээс бусад хэсгийг мөрдөж гаргасан дүн юм.
- 3.4. Хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь гэж татварын хууль тогтоомжийн шаардлагын дагуу тооцсон хөрөнгө буюу өр төлбөрийн дүнг хэлнэ.
- 3.5. Хөрөнгийн татварын суурь нь хөрөнгийн дансны үнийг нөхөх үед байгууллагын олох татвар ногдох аливаа эдийн засгийн өгөөжөөс татварын зорилгоор ирээдүйд хасагдах дүн ба дараах томъёогоор ашиглан тодорхойлж болно:

$$\begin{array}{l} \text{Хөрөнгийн} \\ \text{татварын} \\ \text{суурь} \end{array} = \text{Дансны үнэ} - \begin{array}{l} \text{Ирээдүйд} \\ \text{татвар} \\ \text{ногдох дүн} \end{array} + \begin{array}{l} \text{Ирээдүйд татвар} \\ \text{ногдох орлогоос} \\ \text{хасагдах дүн} \end{array}$$

- 3.6. Хэрэв ирээдүйд олох эдийн засгийн өгөөжид татвар ногдохгүй бол ирээдүйд татвар ногдох дүн болон ирээдүйд татвар ногдох орлогоос хасагдах дүнгийн аль аль нь тэг байх тул хөрөнгийн татварын суурь ба дансны үнэ тэнцүү байна. Улмаар хойшлогдсон татварын үр нөлөө үүсэхгүй.
- 3.7. Өр төлбөрийн татварын суурь нь дансны үнээс ирээдүйн тайлант хугацаанд тухайн өр төлбөртэй холбоотойгоор татварын зорилгоор хасагдах дүнг хассан дүн ба дараах томъёогоор ашиглан тодорхойлж болно:

$$\begin{array}{l} \text{Өр төлбөрийн} \\ \text{татварын} \\ \text{суурь} \end{array} = \text{Дансны үнэ} - \begin{array}{l} \text{Ирээдүйд татвар} \\ \text{ногдох орлогоос} \\ \text{хасагдах дүн} \end{array} + \begin{array}{l} \text{Ирээдүйд} \\ \text{татвар} \\ \text{ногдох дүн} \end{array}$$

- 3.8. Хөрөнгө, өр төлбөр тус бүрийн хувьд татварын суурь, дансны үнийн дэлгэрэнгүй бүртгэл, тооцооллыг хөтөлнө.

ДӨРӨВ. Байнгын ба түр зөрүү

- 4.1. Санхүүгийн тайлан, орлогын албан татварын тайланг бэлтгэх зорилго, баримталж байгаа зарчим, ялгааны улмаас санхүүгийн тайлангаар илэрхийлэгдсэн “татварын өмнөх ашиг (алдагдал)” болон ААНОАТ-ын тайлангийн “татвар ногдуулах орлого (татварын тайлангаарх алдагдал)” зөрүүтэй байна. Үүсч байгаа зөрүүг шинж чанараас нь хамаарч байнгын ба түр зөрүү гэж ангилна.
- 4.2. Санхүүгийн тайлагнал болон татварын тайланд тусгагдах орлого, зардлын зөрүү хэзээ ч арилахгүй бол үүсч буй зөрүүг байнгын зөрүү гэнэ. Байнгын зөрүү нь зөвхөн тайлант хугацааны татварын тооцоонд нөлөө үзүүлэх ба ирээдүйн татварт нөлөөлөхгүй.

4.3. Татварын байнгын зөрүү үүсгэх зарим нөхцлүүд:

- Татвараас чөлөөлөгдөх орлогууд;
- Тусгай хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогууд;
- Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал;
- Татвар ногдох орлогоос хасагдах зардалд тавигдах хязгаарлалтаас давсан зардал;
- Татвар ногдох орлогоос хасаж тооцох зээлийн хүүгийн зардлын хязгаарлалтаас давсан хүүгийн зардал;
- Харилцан хамаарал бүхий этгээдийн хооронд зах зээлийн бус үнээр хийсэн бараа, ажил гүйлгээнд хийсэн үнэ шилжилтийн тохируулга.

Байнгын зөрүү үүсгэх нөхцлүүд нь дээрх жишээгээр хязгаарлагдахгүй.

- 4.4. Хөрөнгө, өр төлбөрийн санхүүгийн тайланд толилуулсан дансны үнэ, татварын суурийн зөрүү нь ирээдүйд дансны үнэ нөхөгдөх буюу барагдуулах үед татвар нөлөөлөл авчрахаар байгаа тохиолдолд түр зөрүү үүснэ.
- 4.5. Хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ ба татварын суурийн зөрүү бүр түр зөрүү үүсгэхгүй. 1.3.5-д заасан нөхцлүүдийг үзнэ үү.
- 4.6. Түр зөрүүг хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ ба татварын суурийн зөрүүгээс түр зөрүүгээр хүлээн зөвшөөрөхгүй зөрүүг хассан дүнгээр хэмжих ба түүнийг татвар ногдох түр зөрүү, хасагдах түр зөрүү гэж ангилна.
- а) Түр зөрүү нь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ нөхөгдөх буюу барагдуулах ирээдүйн тайлант үед татвар ногдуулах орлогыг нэмэгдүүлэх нөлөөлөл үзүүлж байвал түүнийг “Татвар ногдох түр зөрүү” гэнэ.
- б) Түр зөрүү нь хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ нөхөгдөх буюу барагдуулах ирээдүйн тайлант үед татвар ногдуулах орлогыг бууруулах нөлөөлөл үзүүлж байвал түүнийг “Хасагдах түр зөрүү” гэнэ.
- 4.7. Түр зөрүүг анх удаа үүсгэх үед хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ ба татварын сууриас шалтгаалан татвар ногдох түр зөрүү эсхүл хасагдах түр зөрүү болохыг үлгэрчлэн доорх хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1. Татвар ногдох ба хасагдах түр зөрүү

	Хөрөнгийн хувьд	Өр төлбөрийн хувьд
Дансны үнэ > Татварын суурь	Татвар ногдох түр зөрүү үүснэ	Хасагдах түр зөрүү үүснэ
Дансны үнэ < Татварын суурь	Хасагдах түр зөрүү үүснэ	Татвар ногдох түр зөрүү үүснэ
Дансны үнэ=Татварын суурь	Түр зөрүү үүсэхгүй	Түр зөрүү үүсэхгүй

- 4.8. Түр зөрүүг үүссэнээс хойш уг зөрүүг тэглэх хүртэл дээрх байдлаар үүсгэсэн татвар ногдох болон хасагдах түр зөрүүг нэмэгдүүлж эсхүл бууруулж тохируулна.

ТАВ. Хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрөх, хэмжих

- 5.1. 1.3.5-д заасан нөхцлөөс үүссэнээс бусад тохиолдолд татвар ногдох түр зөрүүний хувьд хойшлогдсон татварын өр төлбөрийг заавал хүлээн зөвшөөрнө.
- 5.2. Дараахаас бусад тохиолдолд охин, салбар, хараат компани, хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт, хамтын хэлцэл дэх хувь оролцоотой холбоотой

үүссэн татвар ногдох түр зөрүүнд хойшлогдсон татварын өр төлбөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Үүнд:

- Толгой компани, хөрөнгө оруулагч, хамтарсан оролцогч эсхүл хамтын хэлцлийн оролцогч нь түр зөрүүг буцаах цаг хугацаанд хяналт тавьдаг; ба
- Түр зөрүүг ойрын ирээдүйд буцаахгүй байх магадлалтай.

5.3. Хойшлогдсон татварын өр төлбөрийн үлдэгдлийг дараах томъёогоор тооцоолно. Үүнд:

$$\frac{\text{Хойшлогдсон татварын төлбөр}}{\text{өр}} = \frac{\text{Татвар ногдох түр зөрүү}}{\text{түр зөрүү}} \times \frac{\text{Татварын дундаж хувь хэмжээ}}{\text{хувь хэмжээ}}$$

5.4. 1.3.5-д заасан нөхцлөөс үүссэнээс бусад тохиолдолд хасагдах түр зөрүүг ирээдүйд нөхөх боломжтой үед л хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрнө.

5.5. Зөвхөн дараах нөхцлүүд биелэх магадлалтай үед охин, салбар, хараат компани, хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт, хамтын хэлцэл дэх хувь оролцоотой холбоотой үүссэн хасагдах түр зөрүүнд хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Үүнд:

- Түр зөрүү ойрын ирээдүйд буцаагдах; ба
- Түр зөрүүг ашиглахуйц хэмжээний татвар ногдуулах орлого олох.

5.6. Хойшлогдсон татварын хөрөнгийн үлдэгдлийг дараах томъёогоор тооцоолно. Үүнд:

$$\frac{\text{Хойшлогдсон татварын хөрөнгө}}{\text{хөрөнгө}} = \frac{\text{Хасагдах түр зөрүү}}{\text{түр зөрүү}} \times \frac{\text{Татварын дундаж хувь хэмжээ}}{\text{хувь хэмжээ}}$$

5.7. Хойшлогдсон татварын хөрөнгө ирээдүйд нөхөгдөх боломжтой эсэхийг үнэлэхдээ ирээдүйд татвар ногдуулах хангалттай хэмжээний орлого (хасагдах түр зөрүүний ирээдүй үеийн буцаалтыг оролцуулалгүйгээр) олох эсэх буюу ирээдүйн тайлант үед олохоор хүлээгдэж буй татвар ногдуулах орлогын төсөөлөлд үндэслэнэ. Тухайлбал, дараагийн тайлант үеүдэд алдагдалтай ажиллах магадлалтай байгаа нөхцөлд хасагдах түр зөрүү нөхөгдөхгүй тул хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрч, бүртгэхгүй.

5.8. Татварын тайлангаарх алдагдал ирээдүйд нөхөгдөх боломжтой үед хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

$$\frac{\text{Хойшлогдсон татварын хөрөнгө}}{\text{хөрөнгө}} = \frac{\text{Татварын тайлангаарх алдагдал}}{\text{тайлангаарх алдагдал}} \times \frac{\text{Татварын дундаж хувь хэмжээ}}{\text{хувь хэмжээ}}$$

5.9. Татварын тайлангаар гарсан алдагдал татварын албаар баталгаажуулсан дүн зөрүүтэй тохиолдолд хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын хөрөнгийг залруулж, бүртгэнэ.

5.10. Дараа үед шилжүүлэн тооцох алдагдлыг ашиглах боломжтой эсэхийг үнэлэхийн тулд дараах зүйлсийг харгалзана. Үүнд:

- Алдагдлыг шилжүүлэн тооцох хүчинтэй хугацаа
- Алдагдлыг шилжүүлэн тооцох хүчинтэй хугацаан дахь тайлант үе бүрт ашиглах боломжтой алдагдлын хэмжээнд тавигдах хязгаарлалт гэх мэт.

5.11. Санхүүгийн тайлангийн өдрөөр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хууль тогтоомжид үндэслэн хойшлогдсон татварын тооцоололд хөрөнгийг ашиглагдах эсхүл өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хүчин төгөлдөр байх

татварын хувийг мөрдөнө. Тухайлбал, компани тайлант үед болон ирээдүйн тайлант үеүүдэд 10%-иар татвар төлөх бол татварын дундаж хувийг 10%-иар авна.

- 5.12. Татварын шаталсан хувь хэмжээ мөрдөгдөж байгаа тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжихдээ татварын дундаж хувь хэмжээг ашиглана. Татварын дундаж хувийг дараах томъёогоор тодорхойлно. Үүнд:

$$\text{Татварын дундаж хувь} = \frac{\text{Нийтлэг хувь хэмжээгээр ногдуулахаар хүлээгдэж буй татварын зардал}}{\text{Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын хүлээгдэж буй дүн}}$$

Жишээ: Компанийн ирэх тайлант үед олохоор хүлээгдэж буй татвар ногдуулах орлогын дүн = 5,000.0 сая төгрөг.

Ногдуулах татвар = (3,000.0 * 10% + 2,000.0 * 25%) = 800.0 сая төгрөг

Татварын дундаж хувь = 800.0 / 5,000.0 = 16%

- 5.13. Хүлээгдэж буй орлого, зардлын дүнг найдвартай тооцоолох боломжгүй нөхцөлд тухайн тайлант эсвэл өнгөрсөн жилийн гүйцэтгэлд үндэслэн татварын дундаж хувийг тодорхойлон, ашиглаж болно.

$$\text{Татварын дундаж хувь} = \frac{\text{Тайлант эсвэл өнгөрсөн жилийн нийтлэг хувь хэмжээгээр ногдуулсан татварын зардал}}{\text{Тайлант эсвэл өнгөрсөн жилийн нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын дүн}}$$

- 5.14. Татварын хувь өөрчлөгдсөн тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрт залруулга хийх ба залруулгыг ирээдүйд гүйцээх горимоор бүртгэнэ. Энэ үед татварын хувь өөрчлөгдсөний улмаас өнгөрсөн үеийн санхүүгийн тайланг нөхөж тайлагнахгүй.

- 5.15. Хойшлогдсон татварын хөрөнгийн эцсийн үлдэгдэл ба эхний үлдэгдлийн зөрүүгээр хойшлогдсон татварын зардал, орлогыг тооцоолж, хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны өсөлтөөр хойшлогдсон татварын орлого хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Харин хойшлогдсон татварын хөрөнгийн дансны бууралтаар хойшлогдсон татварын зардал хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

$$\text{Хойшлогдсон татварын (зардал) орлого} = \text{Хойшлогдсон татварын хөрөнгийн эцсийн үлдэгдэл} - \text{Хойшлогдсон татварын хөрөнгийн эхний үлдэгдэл}$$

- 5.16. Хойшлогдсон татварын өр төлбөрийн эцсийн үлдэгдэл ба эхний үлдэгдлийн зөрүүгээр хойшлогдсон татварын зардал, орлогыг тооцоолж, хүлээн зөвшөөрнө. Хойшлогдсон татварын өр төлбөрийн дансны өсөлтөөр хойшлогдсон татварын зардал хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Хойшлогдсон татварын өр төлбөрийн дансны бууралтаар хойшлогдсон татварын орлого хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

$$\text{Хойшлогдсон татварын зардал (орлого)} = \text{Хойшлогдсон татварын өр төлбөрийн эцсийн үлдэгдэл} - \text{Хойшлогдсон татварын өр төлбөрийн эхний үлдэгдэл}$$

- 5.17. Татвар ногдох түр зөрүүг буцааснаар ирээдүйн тайлант үеийн татвар ногдуулах орлогын дүнг өсгөж, харин хасагдах түр зөрүүг буцааснаар ирээдүйн тайлант үеийн татвар ногдуулах орлогын дүнг бууруулна.

ЗУРГАА. Хойшлогдсон татварын толилуулга

- 6.1. Тайлант хугацааны эцсээрх татварын өглөг, авлагын дүнг нэгтгэж, цэвэр дүнгээр санхүүгийн тайланд толилуулж болно.
- 6.2. Тайлант хугацааны эцсээрх хойшлогдсон татварын хөрөнгө ба хойшлогдсон татварын өр төлбөрийн дүнг нэгтгэж, цэвэр дүнгээр санхүүгийн тайланд толилуулж болно.
- 6.3. Хойшлогдсон татварын хөрөнгө эсхүл хойшлогдсон татварын өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд тусдаа мөрөөр эргэлтийн бус хөрөнгө эсхүл урт хугацаат өр төлбөрөөр толилуулна.
- 6.4. Дараахаас бусад тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхдөө хойшлогдсон татварын зардал (орлого)-д бүртгэнэ. Харин доорх нөхцөлд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрснөөр бусад дэлгэрэнгүй орлого буюу эздийн өмчийн дансыг нэмэгдүүлэх буюу бууруулах бичилт хийнэ. Үүнд:
 - Эздийн өмчийн дансанд буюу бусад дэлгэрэнгүй орлогоор хүлээн зөвшөөрсөн ажил гүйлгээ, үйл явдал;
 - Бизнесийн нэгдэл.
- 6.5. Нийлмэл санхүүгийн хэрэглүүрийг НББОУС 32 “Санхүүгийн хэрэглүүр: Толилуулга”-ын дагуу өрийн ба өмчийн хэсэгт салгаж бүртгэсэн нөхцөлд холбогдох хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэхдээ өмчийн хэсэгт бүртгэсэн дүнг бууруулна. Энэ үед хойшлогдсон татварын өр төлбөрийг буцаахдаа хойшлогдсон татварын орлого дансанд бүртгэнэ.
- 6.6. Орлогын дэлгэрэнгүй тайланд хүлээн зөвшөөрч, толилуулах татварын зардал (орлого) нь тайлант үеийн татварын зардал ба хойшлогдсон татварын зардал (орлого)-ын нийлбэрээр тодорхойлогдоно.
- 6.7. Өмнөх тайлант хугацаанд хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг илүү эсвэл дутуу илэрхийлсэн тохиолдолд алдааны залруулга гэж үзэн хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдлийг залруулж, бүртгэнэ.

ДОЛОО. Орлогын албан татварын үлгэрчилсэн журналын бичилт

Орлогын албан татварыг дараах байдлаар нягтлан бодох бүртгэлд тусгана.

- а) Хууль тогтоомжинд заасан татварын хувь хэмжээгээр тооцоолсон, тайлант хугацаанд хамаарах татварыг өглөгөөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Дт Тайлант үеийн татварын зардал
Кт Орлогын албан татварын өглөг

- б) Орлогын албан татварыг урьдчилж төлөхөд татварын авлагад бүртгэнэ.

Дт Орлогын албан татварын авлага
Кт Мөнгөн хөрөнгө

- в) Татварын авлага, өглөгийг хааж цэвэршүүлсэн бол татварын авлага, өглөгийг нэгэн зэрэг бууруулна.

Дт Орлогын албан татварын өглөг
Кт Орлогын албан татварын авлага

- г) Татвар ногдох түр зөрүү үүсвэл хойшлогдсон татварын өр төлбөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Дт Хойшлогдсон татварын зардал
Кт Хойшлогдсон татварын өр төлбөр

- д) Хойшлогдсон татварын өглөгийг буцаах үед хойшлогдсон татварын орлого хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.
- Дт Хойшлогдсон татварын өр төлбөр
Кт Хойшлогдсон татварын орлого
- е) Ирээдүйд нөхөгдөх боломжтой хасагдах түр зөрүү үүссэн үед хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.
- Дт Хойшлогдсон татварын хөрөнгө
Кт Хойшлогдсон татварын орлого
- ё) Хойшлогдсон татварын хөрөнгийг буцаах үед хойшлогдсон татварын зардалд бүртгэнэ.
- Дт Хойшлогдсон татварын зардал
Кт Хойшлогдсон татварын хөрөнгө
- ж) Дараа жилүүдэд шилжүүлэх татварын тайлангаарх алдагдлын хувьд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрөхдөө хойшлогдсон татварын орлогод бүртгэнэ.
- Дт Хойшлогдсон татварын хөрөнгө
Кт Хойшлогдсон татварын орлого
- з) Татварын тайлангаарх алдагдлыг дараа жилүүдэд шилжүүлэх үед хойшлогдсон татварын хөрөнгийг бууруулж, хойшлогдсон татварын зардалд бүртгэнэ.
- Дт Хойшлогдсон татварын зардал
Кт Хойшлогдсон татварын хөрөнгө
- и) Дараа жилүүдэд шилжүүлэлгүй үлдсэн татварын тайлангаарх алдагдлыг буцаахдаа хойшлогдсон татварын хөрөнгийн үлдэгдлийг татварын зардалд хааж бүртгэнэ.
- Дт Хойшлогдсон татварын зардал
Кт Хойшлогдсон татварын хөрөнгө
- й) Бусад дэлгэрэнгүй орлоготой холбоотой эсхүл эздийн өмчид шууд хүлээн зөвшөөрөх татвар ногдох түр зөрүү үүсвэл хойшлогдсон татварын өр төлбөр хүлээн зөвшөөрнө.
- Дт Бусад дэлгэрэнгүй орлого
Кт Хойшлогдсон татварын өр төлбөр
- к) Дээрх нөхцөлд хойшлогдсон татварын өглөгийг буцаахдаа харгалзах бусад дэлгэрэнгүй орлого эсхүл эздийн өмчийн дансыг буцааж, бүртгэнэ.
- Дт Хойшлогдсон татварын өр төлбөр
Кт Бусад дэлгэрэнгүй орлого
- л) Бусад дэлгэрэнгүй орлоготой холбоотой эсхүл эздийн өмчид шууд хүлээн зөвшөөрөх хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрнө.
- Дт Хойшлогдсон татварын хөрөнгө
Кт Бусад дэлгэрэнгүй орлого
- м) Дээрх нөхцөлд хойшлогдсон татварын хөрөнгийг буцаахдаа харгалзах бусад дэлгэрэнгүй орлого эсхүл эздийн өмчийн дансыг буцааж, бүртгэнэ.
- Дт Бусад дэлгэрэнгүй орлого
Кт Хойшлогдсон татварын хөрөнгө

НАЙМ. Үлгэрчилсэн жишээ

Жишээ 1 - Гадаад валютаарх өглөг

Он, сар, өдөр	Ажил гүйлгээ, үйл явдал	Ам.доллар төгрөгтэй харилцах албан ханш	Санхүүгийн бүртгэл	Татварын бүртгэл
20x1/05/01	10,000 ам.долларын бараа материал гадаадын бэлтгэн нийлүүлэгчээс зээлээр худалдан авсан.	2489.53	Дт Бараа материал 24,895,300 Кт Дансны өглөг 24,895,300	Татварын суурь: Бараа материал 24,895,300 Дансны өглөг 24,895,300
20x1/05/15	5,000 ам.долларын төлбөрийг шилжүүлсэн	2475.1	Дт Дансны өглөг 12,447,650 Кт Мөнгөн хөрөнгө 12,375,500 Кт Валютын ханшийн хэрэгжсэн ашиг 72,150	Дансны өглөгийн татварын суурь – 12,447,650 Валютын ханшийн хэрэгжсэн буюу бодит ашиг нь татвар ногдох орлого болно.
20x1/06/30	Гадаад валютаарх дансны үлдэгдэлд ханшийн тэгшитгэл хийсэн.	2465.3	Дт Дансны өглөг 121,150 Кт Валютын ханшийн хэрэгжээгүй ашиг 121,150	Валютын ханшийн хэрэгжээгүй буюу бодит бус ашиг нь татвар ногдох орлого тул дансны өглөгийн дансны үнэ ба татварын суурь зөрүүтэй болно.
20x1/07/15	3,000 ам.долларын төлбөрийг шилжүүлсэн	2473.2	а) Дт Дансны өглөг 7,395,900 Дт Валютын ханшийн хэрэгжсэн алдагдал 23,700 Кт Мөнгөн хөрөнгө 7,419,600 б) Дт Валютын ханшийн хэрэгжээгүй ашиг 72,690 (3000*(2489.53-2465.30)) Кт Валютын ханшийн хэрэгжсэн ашиг 72,690	Валютын ханшийн хэрэгжсэн ашгийг татвар ногдох орлогоор, валютын ханшийн хэрэгжсэн алдагдалыг татвар ногдох орлогоос хасагдах зардлаар татварын тайланд тусгана. Ингэснээр татвар ногдуулах орлогыг 48,990 төгрөгөөр (3000*(2473.20-2489.53)) нэмэгдүүлэх нөлөө үзүүлнэ.
20x1/12/31	Гадаад валютаарх дансны үлдэгдэлд ханшийн тэгшитгэл хийсэн.	2462.2	Дт Дансны өглөг 6,200 Кт Валютын ханшийн хэрэгжээгүй ашиг 6,200	Валютын ханшийн хэрэгжээгүй буюу бодит бус ашиг нь татвар ногдох орлого тул дансны өглөгийн дансны үнэ ба татварын суурь зөрүүтэй болно.
20x2/01/10	Үлдэгдэл 2,000 ам.долларын төлбөрийг шилжүүлсэн	2471.2	Дт Дансны өглөг 4,924,400 Дт Валютын ханшийн хэрэгжсэн алдагдал 18,000 Кт Мөнгөн хөрөнгө 4,942,400	Нягтлан бодох бүртгэлийн зорилгоор валютын ханшийн бодит алдагдал үүсэх хэдий ч татвар зорилгоор валютын ханшийн бодит ашиг 36,660 төгрөг (2000*(2471.20-2489.53)) үүснэ.

Хойшлогдсон татварын тооцоолол:

	Огноо	Дансны өглөгийн		Түр зөрүү	ХТХ эсхүл ХТӨТ	Татварын хувь хэмжээ	ХТӨТ-ийн эцсийн үлдэгдэл	Хойшлогдсон татварын зардал (орлого)
		Дансны үнэ	Татварын суурь					
1	20x1/05/01	24,895,300	24,895,300	-	-			
2	20x1/05/15	12,447,650	12,447,650	-	-			
3	20x1/06/30	12,326,500	12,447,650	(121,150)	ХТӨТ	10%	12,115	12,115
4	20x1/07/15	4,930,600	4,979,060	(48,460)	ХТӨТ	10%	4,846	(7,269)
5	20x1/12/31	4,924,400	4,979,060	(54,660)	ХТӨТ	10%	5,466	620

6	20x2/01/10	-	-	-		0	(5,466)
---	------------	---	---	---	--	---	---------

Журналын бичилт:

20x1/06/30-нд татвар ногдох түр зөрүүнд үндэслэн хойшлогдсон татварын өр төлбөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ:

Дт Хойшлогдсон татварын зардал	12,115
Кт Хойшлогдсон татварын өр төлбөр	12,115

20x1/07/15-нд өр төлбөрийн дансны үнэ ба татварын суурьд өөрчлөлт гарсан тул өмнө хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын өр төлбөрт холбогдох буцаалтыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ:

Дт Хойшлогдсон татварын өр төлбөр	7,269
Кт Хойшлогдсон татварын орлого	7,269

20x1/12/31-нд ханшийн тэгшитгэлийн нөлөөгөөр өр төлбөрийн дансны үнэ өөрчлөгдөж, улмаар татвар ногдох түр зөрүүний дүн өссөн тул хойшлогдсон татварын өр төлбөрийн нэмэгдсэн дүнг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ:

Дт Хойшлогдсон татварын зардал	620
Кт Хойшлогдсон татварын өр төлбөр	620

20x2/01/10-нд өр төлбөр бүрэн барагдаж дуусан тул хойшлогдсон татварын өр төлбөрийн үлдэгдлийн буцаалтыг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ:

Дт Хойшлогдсон татварын өр төлбөр	5,466
Кт Хойшлогдсон татварын орлого	5,466

Жишээ 2 - Үндсэн хөрөнгийн анх хүлээн зөвшөөрөлт ба элэгдлийн зөрүү

Компани 600.0 сая төгрөгийн өртөг бүхий барилгыг худалдан авсан ба уг хөрөнгийн 50%-ийг албан татвар ногдох орлого олох зорилгоор ашиглана. Санхүүгийн бүртгэлийн зорилгоор 15 жил, татварын зорилгоор 25 жилд шулуун шугамын аргаар тус тус элэгдүүлнэ. Татварын хувь хэмжээ 10%.

Энэ нөхцөлд, 1.3.5-д заасны дагуу хөрөнгийн анх хүлээн зөвшөөрөлттэй холбоотой татвар ногдуулах орлого (татварын тайлангийн алдагдал)-д нөлөө үзүүлэхгүй түр үүсч буй тул түр зөрүүгээр хүлээн зөвшөөрөхгүй зөрүү үүсч байна.

Хойшлогдсон татварын тооцооллыг Хавсралт 1-д тусгасан “Түр зөрүүг тооцоолох үлгэрчилсэн ажлын хүснэгт”-ийг ашиглах дараах байдлаар тооцоолж болно:

Жил	Дансны үнэ /мян.төг/		Татварын суурь /мян.төг/		Зөрүү /мян.төг/		Түр зөрүүгээр хүлээн зөвшөөрөхгүй зөрүү /мян.төг/		Түр зөрүүгээр хүлээн зөвшөөрөх зөрүү		Хүлээн зөвшөөрсөн түр зөрүүгийн тайлант үеийн өөрчлөлт	Хойшлогд- сон татвар
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		
1	600,000	560,000	300,000	288,000	300,000	272,000	300,000	280,000	0	- 8,000	- 8,000	- 800
2	560,000	520,000	288,000	276,000	272,000	244,000	280,000	260,000	-8,000	- 16,000	- 8,000	- 800
3	520,000	480,000	276,000	264,000	244,000	216,000	260,000	240,000	-16,000	- 24,000	- 8,000	- 800
4	480,000	440,000	264,000	252,000	216,000	188,000	240,000	220,000	-24,000	- 32,000	- 8,000	- 800
5	440,000	400,000	252,000	240,000	188,000	160,000	220,000	200,000	-32,000	- 40,000	- 8,000	- 800
6	400,000	360,000	240,000	228,000	160,000	132,000	200,000	180,000	-40,000	- 48,000	- 8,000	- 800
7	360,000	320,000	228,000	216,000	132,000	104,000	180,000	160,000	-48,000	- 56,000	- 8,000	- 800
8	320,000	280,000	216,000	204,000	104,000	76,000	160,000	140,000	-56,000	- 64,000	- 8,000	- 800
9	280,000	240,000	204,000	192,000	76,000	48,000	140,000	120,000	-64,000	- 72,000	- 8,000	- 800
10	240,000	200,000	192,000	180,000	48,000	20,000	120,000	100,000	-72,000	- 80,000	- 8,000	- 800
11	200,000	160,000	180,000	168,000	20,000	- 8,000	100,000	80,000	-80,000	- 88,000	- 8,000	- 800
12	160,000	120,000	168,000	156,000	-8,000	- 36,000	80,000	60,000	-88,000	- 96,000	- 8,000	- 800
13	120,000	80,000	156,000	144,000	-36,000	- 64,000	60,000	40,000	-96,000	- 104,000	- 8,000	- 800
14	80,000	40,000	144,000	132,000	-64,000	- 92,000	40,000	20,000	-104,000	- 112,000	- 8,000	- 800
15	40,000	-	132,000	120,000	-92,000	- 120,000	20,000	-	-112,000	- 120,000	- 8,000	- 800
16	0	-	120,000	108,000	-120,000	- 108,000			-120,000	- 108,000	12,000	1,200
17			108,000	96,000	-108,000	- 96,000			-108,000	- 96,000	12,000	1,200
18			96,000	84,000	-96,000	- 84,000			-96,000	- 84,000	12,000	1,200
19			84,000	72,000	-84,000	- 72,000			-84,000	- 72,000	12,000	1,200
20			72,000	60,000	-72,000	- 60,000			-72,000	- 60,000	12,000	1,200
21			60,000	48,000	-60,000	- 48,000			-60,000	- 48,000	12,000	1,200
22			48,000	36,000	-48,000	- 36,000			-48,000	- 36,000	12,000	1,200
23			36,000	24,000	-36,000	- 24,000			-36,000	- 24,000	12,000	1,200
24			24,000	12,000	-24,000	- 12,000			-24,000	- 12,000	12,000	1,200
25			12,000	-	-12,000	-			-12,000	-	12,000	1,200

Түр зөрүүг бүртгэх журналын бичилт:

Дээрх хүснэгт дэх тооцооллоос харахад хөрөнгийн ашиглалтын эхний 15 жилд хүлээн зөвшөөрөх хойшлогдсон татварын орлогын дүн жил бүр 800.0 мянган төгрөг байх ба үүнийг дараах байдлаар бүртгэлд тусгана. Үүнд:

Дт Хойшлогдсон татварын хөрөнгө 800.0
Кт Хойшлогдсон татварын орлого 800.0

15 дахь жилийн эцэст хөрөнгийн дансны үнэ үлдэгдэлгүй болсон хэдий ч татварын суурьтай байна. Иймд 16 дахь жилээс эхлэн дараагийн 10 жилд хойшлогдсон татварын хөрөнгийг буцаах бичилтийг байдлаар бүртгэлд тусгана. Үүнд:

Дт Хойшлогдсон татварын зардал 1,200
Кт Хойшлогдсон татварын хөрөнгө 1,200

Дээрх бичилтийг хийснээр 25 дахь жилийн эцэст хойшлогдсон татварын хөрөнгө данс үлдэгдэлгүй болж, түр зөрүү тэглэнэ.

Жишээ 3 - Алдагдал хойшлуулах

"А" компани 20х0 онд татварын тайлангаар 500.0 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. Холбогдох хууль тогтоомжийн дагуу уг алдагдлыг татварын албаар баталгаажуулсан. Татварын хуулийн дагуу компани алдагдалтай ажилласан татварын жилийн дараах дараалсан 4 жилд уг баталгаажуулсан алдагдлыг ашиглах боломжтой ба ингэхдээ жил тус бүрийн татвар ногдуулах орлогын 50 хувиар хязгаарлагдана. Компанийн татварын ногдуулах орлого дараагийн 4 жилд 360.0, 100.0, 200.0 ба 300.0 сая төгрөг тус тус байсан.

Алдагдал шилжүүлэн тооцооллолт:

Үзүүлэлт	Жилүүд /сая.төг/				
	20x0 он	20x1 он	20x2 он	20x3 он	20x4 он
Татвар ногдуулах орлого (+ ашиг, - алдагдал)	- 500.0	360.0	100.0	200.0	300.0
Шилжүүлэн тооцох алдагдлын боломжит дүн		180.0	50.0	100.0	150.0
Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлого		180.0	50.0	100.0	150.0
Ногдуулсан орлогын албан татвар (10%)	- 50.0	18.0	5.0	10.0	15.0
Ашиглагдаагүй алдагдлын үлдэгдэл		- 320.0	- 270.0	- 170.0	- 20.0

“Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан”-гийн Г хэсгийг дараах байдлаар бэлтгэнэ:

В. ТАТВАРЫН ТАЙЛАНГААР ГАРСАН АЛДАГДЛЫН ТООЦООЛОЛ	Мөрийн дугаар	Онууд				
		20x0	20x1	20x2	20x3	20x4
Өмнөх жилүүдийн татварын тайлангаар гарсан алдагдлын эхний үлдэгдэл	14		500.0	320.0	270.0	170.0
Ирээдүйд нөхөгдөхөөр хүлээгдэж буй тайлант хугацаанд шинээр үүссэн алдагдлын дүн	15	- 500.0				
Тайлант хугацаанд өмнөх жилүүдийн алдагдлаас шилжүүлэн тооцсон дүн	16		180.0	50.0	100.0	150.0
Алдагдлыг (буцаах) эсвэл нэмэгдүүлэх залруулга	17					- 20.0
Татварын тайлангаар гарсан алдагдлын эцсийн үлдэгдэл (мөр 14+15-16+17)	18	500.0	320.0	270.0	170.0	-

Журналын бичилт:

20x0 онд баталгаажуулсан татварын тайлангаарх алдагдалын хувьд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Дт Хойшлогдсон татварын хөрөнгө 50.0
Кт Хойшлогдсон татварын орлого 50.0

20x1 онд 20x0 оны баталгаажсан татварын алдагдлаас ашиглах үед:

Дт Тайлант үеийн татварын зардал 18.0
Дт Хойшлогдсон татварын зардал 18.0
Кт Тайлант үеийн татварын өглөг 18.0
Кт Хойшлогдсон татварын хөрөнгө 18.0

20x2 онд 20x0 оны баталгаажсан татварын алдагдлаас ашиглах үед:

Дт Тайлант үеийн татварын зардал 5.0
Дт Хойшлогдсон татварын зардал 5.0
Кт Тайлант хугацааны татварын өглөг 5.0
Кт Хойшлогдсон татварын хөрөнгө 5.0

20x3 онд 20x0 оны баталгаажсан татварын алдагдлаас ашиглах үед:

Дт Тайлант үеийн татварын зардал 10.0
Дт Хойшлогдсон татварын зардал 10.0
Кт Тайлант хугацааны татварын өглөг 10.0
Кт Хойшлогдсон татварын хөрөнгө 10.0

20x4 онд 20x0 оны баталгаажсан татварын алдагдлаас ашиглах үед:

Дт Тайлант үеийн татварын зардал 15.0
Дт Хойшлогдсон татварын зардал 15.0

Кт Тайлант хугацааны татварын өглөг	15.0
Кт Хойшлогдсон татварын хөрөнгө	15.0

20х4 оны эцэст ашиглаагүй үлдсэн алдагдлын хувьд хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын хөрөнгийг буцаахад:

Дт Хойшлогдсон татварын зардал	2.0
Кт Хойшлогдсон татварын хөрөнгө	2.0

Жишээ 4 - Ажил гүйлгээний өртөг

Санхүүгийн байгууллага 6 сая төгрөгийн зээлийг 3 жилийн хугацаагаар, жилийн 12%-ийн хүүтэй олгосон. Зээл олгохтой холбоотой төлөгдсөн 60,000 төгрөгийн шимтгэлийг хойшлуулж бүртгэсний улмаас зээлийг анх хүлээн зөвшөөрөх дүн 5,940,000 төгрөг болсон. Татварын зорилгоор шимтгэлийг анх төлөгдсөн үед нь татвар ногдуулах орлогод оруулж, татвар ногдуулдаг гэж үзье.

Дансны үнийн тооцоолол (мянган төгрөгөөр):

Жилүүд	Зээлийн үлдэгдэл	Хойшлогдсон орлогын үлдэгдэл	Хүүгийн орлого	Хойшлогдсон орлогын хорогдол	Зээлийн дансны үнэ
0	6,000.0	60.0			5,940.0
1	6,000.0	37.5	697.46	22.54	5,962.5
2	6,000.0	17.6	700.10	19.90	5,982.4
3	-	(0.0)	702.44	17.56	0.0

Зээлдэгчийн хувьд зээл олголтын шимтгэл төлөгдсөн үед татвар ногдуулбал татварын түр зөрүү үүснэ.

Татварын зөрүүгийн тооцоолол (мянган төгрөгөөр):

Жилүүд	Зээлийн дансны үнэ	Зээлийн татварын суурь	Түр зөрүү	Хойшлогдсон татварын хөрөнгө	Хойшлогдсон татварын зардал (орлого)
0	5,940.0	6,000.0	(60.0)	6.0	(6.0)
1	5,963.0	6,000.0	(37.0)	3.7	2.30
2	5,982.0	6,000.0	(18.0)	1.8	1.90
3	-	-	-	-	1.80

Түр зөрүүг бүртгэх журналын бичилт:

Зээлийг хүлээн зөвшөөрөх үед үүссэн татварын зөрүүгээр хойшлогдсон татварын хөрөнгө бүртгэнэ.

Дт Хойшлогдсон татварын хөрөнгө	6,000
Кт Хойшлогдсон татварын орлого	6,000

Эхний тайлант жилийн эцэст хойшлогдсон орлогыг хорогдуулсны улмаас зээлийн дансны үнэ 5,962,500 төгрөг болох ба үүний улмаас татварын түр зөрүү буурах тул үүнд харгалзах хойшлогдсон татварын хөрөнгийг бууруулж бүртгэнэ.

Дт Хойшлогдсон татварын зардал	2,300
Кт Хойшлогдсон татварын хөрөнгө	2,300

Энэ мэтчилэн дээрх тооцоололд байгаа дүнгээр хойшлогдсон татварын хөрөнгийг бууруулсаар 3 дахь жилийн төгсгөлд түр зөрүү тэглэж, үлдэгдэлгүй болно.

Жишээ 5 - Хөрөнгийн дахин үнэлгээ

Компани 200 сая төгрөгийн анхны өртөг, 80 сая төгрөгийн дансны үнэтэй барилга байгууламжийг дахин үнэлж, дансны үнийг 32 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. Татварын хуулиар зорилгоор дахин үнэлгээний нэмэгдэл хэсгийн дүнд элэгдэл тооцохгүй. Дахин

үнэлгээ хийхээс өмнө хөрөнгийн дансны үнэ, татварын суурь тэнцүү байсан тул түр зөрүү үүсгээгүй байсан. Татварын хувь хэмжээ 10%. Хөрөнгийг цаашид 4 жил ашиглана.

Татварын зөрүүгийн тооцоолол (мянган төгрөгөөр):

Жил	Дансны үнэ	Санхүүгийн элэгдэл	Татварын суурь	Татварын элэгдэл	Татвар ногдох түр зөрүү	Хойшлогдсон татварын өр төлбөр	Хойшлогдсон татварын зардал (орлого)
0	112,000.0		80,000.0		32,000.0	3,200.0	3,200.0
1	84,000.0	28,000.0	60,000.0	20,000.0	24,000.0	2,400.0	(800.0)
2	56,000.0	28,000.0	40,000.0	20,000.0	16,000.0	1,600.0	(800.0)
3	28,000.0	28,000.0	20,000.0	20,000.0	8,000.0	800.0	(800.0)
4	-	28,000.0		20,000.0	-	-	(800.0)

Түр зөрүүг бүртгэх журналын бичилт:

Хөрөнгийн дахин үнэлгээг бүртгэсний дараа хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхдөө татварын зардалд бүртгэхгүй харин дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулна.

Дт Дахин үнэлгээний нэмэгдэл 3,200.0
Кт Хойшлогдсон татварын өр төлбөр 3,200.0

Эхний тайлант жилийн эцэст нягтлан бодох бүртгэлийн элэгдэл, татварын элэгдэл зөрсний улмаас түр зөрүү буурч, улмаар хойшлогдсон татварын өр төлбөрийг бууруулна.

Дт Хойшлогдсон татварын өр төлбөр 800.0
Кт Хойшлогдсон татварын орлого 800.0

Энэ мэтчилэн дээрх тооцоололд байгаа дүнгээр хойшлогдсон татварын хөрөнгийг бууруулсаар 4 дэх жилийн төгсгөлд түр зөрүү тэглэнэ.

Жишээ 6 - Бодит үнэ цэнийн үнэлгээний тохируулга

Компани биржээс идэвхитэй арилжаалагддаг үнэт цаасыг 300 сая төгрөгөөр худалдан авсан ба СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр -ийн дагуу бодит үнэ цэнээр үнэлж бүртгэхээр болсон. Татварын хувь 10%.

Он, сар, өдөр	Ажил гүйлгээ, үйл явдал	Нягтлан бодох бүртгэлд тусгах нь	Татварын зорилгоор хандах нь
20x1/03/01	Компани биржээс идэвхитэй арилжаалагддаг үнэт цаасыг 300 сая төгрөгөөр худалдан авсан.	СТОУС 9-ийн дагуу бодит үнэ цэнээр үнэлж бүртгэхээр болсон. Дт Үнэт цаас 300,000.0 Кт Мөнгөн хөрөнгө 300,000.0	Энэ өдрөөр үнэт цаасны нягтлан бодох бүртгэлийн суурь ба татварын суурь нь адилхан 300 сая төгрөг болох тул түр зөрүү үүсэхгүй.
20x1/12/31	Үнэт цаасны бодит үнэ цэн 310 сая төгрөг болж өссөн.	Дт Үнэт цаас 10,000.0 Кт Үнэлгээний ашиг 10,000.0 Дт Хойшлогдсон татварын зардал 1,000.0 Кт ХТӨТ 1,000.0	Татвар ногдох түр зөрүү 10,000.0 Хойшлогдсон татварын өр төлбөр 1,000.0
20x2/07/20	Эзэмшиж буй үнэт цаасныхаа тэн хагасыг 162 сая төгрөгөөр арилжаалсан.	Дт Мөнгөн хөрөнгө 162,000.0 Кт Үнэт цаас 155,000.0 Кт Арилжааны ашиг 7,000.0	

Он, сар, өдөр	Ажил гүйлгээ, үйл явдал	Нягтлан бодох бүртгэлд тусгах нь	Татварын зорилгоор хандах нь
20x2/12/31	Үнэт цаасны бодит үнэ цэн 130 сая төгрөг болж буурсан.	Дт Үнэлгээний алдагдал 25,000.0 Кт Үнэт цаас 25,000.0 Дт ХТӨТ 1,000.0 Дт ХТХ 2,000.0 Кт Хойшлогдсон татварын орлого 3,000.0	Татвар ногдох түр зөрүү тэглэж, хасагдах түр зөрүү үүснэ.
20x3/06/30	Эзэмшиж буй үнэт цаасаа 162 сая төгрөгөөр арилжаалсан.	Дт Мөнгөн хөрөнгө 162,000.0 Кт Үнэт цаас 155,000.0 Кт Арилжааны ашиг 7,000.0 Дт Хойшлогдсон татварын зардал 2,000.0 Кт ХТХ 2,000.0	Түр зөрүү тэглэнэ.

Татварын зөрүүгийн тооцоолол (мянган төгрөгөөр):

Хугацаа	Дансны үнэ	Татварын суурь	Татвар ногдох (Хасагдах) түр зөрүү	Хойшлогдсон татварын өр	Татварын зардлын өсөлт (бууралт)
20x1/03/01	300,000.0	300,000.0	-	-	-
20x1/12/31	310,000.0	300,000.0	10,000.0	1,000.0	1,000.0
20x2/07/20	155,000.0	150,000.0	5,000.0	500.0	(500.0)
20x2/12/31	130,000.0	150,000.0	(20,000.0)	(2,000.0)	(2,500.0)
20x3/06/30	-	-	-	-	2,000.0

Жишээ 7 - Түр зөрүүгийн тооцоолол ба бүртгэл

Дараах жишээ нь НББОУС 12 “Орлогын албан татвар”-т орсон хавсралт жишээ болно. Аж ахуйн нэгжийн хувьд жишээнд дурдсанаар өөр ажил гүйлгээ гараагүй гэж үзсэн.

Аж ахуйн нэгж 10,000₮-аар тоног төхөөрөмж худалдаж авсан ба нягтлан бодох бүртгэлийн зорилгоор түүний ашиглахаар хүлээгдэж буй 5 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Харин татварын зорилгоор тоног төхөөрөмжийг шулуун шугамын аргаар 25%-аар элэгдүүлнэ. Татварын тайлангаарх алдагдлыг өмнөх таван жилийн татвар ногдуулах орлогоос урагш шилжүүлэн тооцох боломжтой. Аж ахуйн нэгжийн татвар ногдуулах орлого 20X0 онд 5,000₮ байсан. Татварын хувь хэмжээ 40%.

Аж ахуйн нэгж тоног төхөөрөмжийг бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлд ашиглах замаар түүний дансны үнийг нөхнө. Аж ахуйн нэгжийн тайлант үеийн татварын тооцооллыг харуулбал:

	Тайлант хугацаа				
	20X1 он	20X2 он	20X3 он	20X4 он	20X5 он
Татвар ногдох орлого	2,000	2,000	2,000	2,000	2,000
Татварын зорилгоорх элэгдэл	2,500	2,500	2,500	2,500	-
Татвар ногдуулах орлого (алдагдал)	(500)	(500)	(500)	(500)	2,000
Тайлант үеийн татварын зардал (орлого)	(200)	(200)	(200)	(200)	800

Аж ахуйн нэгж 20X1-20X4 онуудын татварын тайлангаарх алдагдлыг 20X0 оны татвар ногдуулах орлого руу шилжүүлэх замаар татварын тайлангаарх алдагдлыг нөхөх тул эдгээр жилүүдэд тайлант үеийн татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Тоног төхөөрөмжтэй холбоотой үүсэх түр зөрүү, түүний үр дүнд үүсэх хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр, хойшлогдсон татварын зардал, орлогын тооцооллыг харуулбал:

	Тайлант хугацаа				
	20X1 он	20X2 он	20X3 он	20X4 он	20X5 он
Дансны үнэ	8,000	6,000	4,000	2,000	-
Татварын суурь	7,500	5,000	2,500	-	-
Татвар ногдох түр зөрүү	500	1,000	1,500	2,000	-

Хойшлогдсон татварын өр төлбөрийн эхний үлдэгдэл	-	200	400	600	800
Хойшлогдсон татварын зардал (орлого)	200	200	200	200	(800)
Хойшлогдсон татварын өр төлбөрийн эцсийн үлдэгдэл	200	400	600	800	-

Татвар ногдох түр зөрүү ирээдүйн тайлант үед татвар ногдуулах орлогыг бий болгох тул аж ахуйн нэгж 20Х1-20Х4 онуудад хойшлогдсон татварын өр төлбөр хүлээн зөвшөөрч, бүртгэнэ. Аж ахуйн нэгжийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн тооцооллыг харуулбал:

	Тайлант хугацаа				
	20Х1 он	20Х2 он	20Х3 он	20Х4 он	20Х5 он
Орлого	2,000	2,000	2,000	2,000	2,000
Элэгдэл	2,000	2,000	2,000	2,000	2,000
Татварын өмнөх ашиг	0	0	0	0	0
Тайлант үеийн татварын зардал (орлого)	(200)	(200)	(200)	(200)	800
Хойшлогдсон татварын зардал (орлого)	200	200	200	200	(800)
Татварын зардлын нийт дүн	0	0	0	0	0
Тайлант үеийн цэвэр ашиг	0	0	0	0	0

Жишээ 8 - Санхүүгийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах тайлан бэлтгэх

Дараах жишээ нь НББОУС 12 “Орлогын албан татвар”-т орсон хавсралт жишээ болно. Татварын хууль тогтоомжийн онцлогоос хамаарч жишээнд дурдагдсан зарим Монгол Улсын хувьд ялгаатай байж болно.

Аж ахуйн нэгжийн хувьд жишээнд дурдсанаар өөр ажил гүйлгээ гараагүй гэж үзсэн.

Доор жишээнд аж ахуйн нэгжийн 20Х5 ба 20Х6 гэсэн хоёр тайлант жил хамрагдсан. Татварын хувь хэмжээ 20Х5 онд 40% байсан бол 20Х6 онд 35% болсон.

Аж ахуйн нэгжээс бусдад өгсөн хандив тусламжийг төлөгдсөн даруйд нь зардалд хүлээн зөвшөөрч, бүртгэх ба энэ нь албан татвар ногдох орлогоос хасагдахгүй зардалд багтана.

20Х5 онд үйлдвэрлэлийн явцад хорт хий ялгарсан шалтгаанаар эрх бүхий байгууллагаас торгох болсныг мэдэгдсэн. 20Х6 оны 12-р сарын байдлаар аж ахуйн нэгж дээрх торгуулийг хараахан төлөөгүй боловч үүнд зориулан 700 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн. Торгуулийг албан татвар ногдох орлогоос хасагдах зардалд оруулдаггүй.

20Х2 онд шинэ бүтээгдэхүүний судалгаа хөгжүүлэлттэй холбоотой 1,250,000 төгрөгийн зардал гарсан. Энэ зардлыг 20Х2 оны татварын тайланд хасагдах зардалд оруулан тайлагнасан. Нягтлан бодох бүртгэлийн зорилгоор энэ зардлыг капиталжуулаад, 5 жилийн хугацаанд шулуун шугамын аргаар хорогдуулна. 20Х4 оны 12-р сарын 31-нд энэхүү судалгаа хөгжүүлэлтийн зардлын хорогдуулаагүй үлдэгдэл нь 500,000 төгрөг байсан.

20Х5 онд аж ахуйн нэгж тэтгэвэрт гарсан ажилтнууддаа зориулсан эрүүл мэндийн халамжийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр ажилтнуудтайгаа гэрээ байгуулсан. Үүнтэй холбогдуулан хүлээн зөвшөөрсөн зардлыг нөөцийн дансанд хуримтлуулж, өр төлбөрөөр тайлагнасан. 20Х5, 20Х6 онуудад уг хөтөлбөрийн дагуу тэтгэвэрт гарсан ажилтанд ямар нэгэн төлбөр хийгдээгүй.

Барилгыг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор 5%-иар шулуун шугамын аргаар, харин татварын зорилгоор 10%-иар шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Тээврийн хэрэгслийг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор 20%-иар шулуун шугамын аргаар, харин татварын зорилгоор 25%-иар шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

20Х6 оны 1-р сарын 1-нд барилгад дахин үнэлгээ хийж, 65 сая төгрөгөөр үнэлж, цаашид ашиглагдах хугацааг нь 20 жил болгон өөрчилсөн. Хөрөнгийн дахин үнэлгээ нь татварын суурийн тооцоонд нөлөөлөхгүй. 20Х6 онд барилгын элэгдлийн бодит зардал (3,250,000₮) ба өртгөөс тооцоолсон эквивалент элэгдлийн зардал (20Х6.01.01-ээрх дансны үнэ 1,660,000₮-ийг

үлдээж буй ашиглалтын хугацаа 20 жилд хувааж гаргасан) -ын зөрүү 1,590,000₮-өөс 557,000₮-ийн хойшлогдсон татварыг хасаж гаргасан 1,033,000 төгрөгийг хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данснаас хуримтлагдсан ашигруу хаасан.

Тайлант үеийн татварын зардлын тооцоо (мянган төгрөгөөр)

	20X5 он	20X6 он
1 Санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийн дүн	8,775	8,740
2 Нэмэх нь:		
Нягтлан бодох бүртгэлийн зорилгоор тооцсон элэгдэл	4,800	8,250
Хандив тусламжийн зардал	500	350
Торгуулийн зардал	700	-
Судалгаа, хөгжүүлэлтийн зардал	250	250
Эрүүл мэндийн халамжийн хөтөлбөрийн зардал	2,000	1,000
	<u>17,025</u>	<u>18,590</u>
3 Хасах нь:		
Татварын зорилгоор тооцсон элэгдэл	8,100	11,850
4 Татвар ногдуулах орлого	<u>8,925</u>	<u>6,740</u>
Тайлант үеийн татварын зардал (40%)	3,570	
Тайлант үеийн татварын зардал (35%)		2,359

Үндсэн хөрөнгийн дансны үнийн тооцоо (мянган төгрөгөөр)

	Барилга	Тээврийн хэрэгсэл	Нийт дүн
Анхны өртөг:			
20X4 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	50,000	10,000	60,000
20X5 онд худалдан авсан хөрөнгийн дүн	6,000	-	6,000
20X5 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<u>56,000</u>	<u>10,000</u>	<u>66,000</u>
20X6 онд хийсэн дахин үнэлгээ	31,800	-	31,800
Дахин үнэлгээгээр хуримтлагдсан элэгдлийг хаасан дүн	(22,800)	-	(22,800)
20X6 онд худалдан авсан хөрөнгийн дүн	-	15,000	15,000
20X6 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<u>65,000</u>	<u>25,000</u>	<u>90,000</u>
Хуримтлагдсан элэгдэл:			
20X4 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,000	4,000	24,000
20X5 оны элэгдлийн зардал	2,800	2,000	4,800
20X5 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<u>22,800</u>	<u>6,000</u>	<u>28,800</u>
20X6 онд хийсэн дахин үнэлгээ	(22,800)	-	(22,800)
20X6 оны элэгдлийн зардал	3,250	5,000	8,250
20X6 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<u>3,250</u>	<u>11,000</u>	<u>14,250</u>
Дансны үнэ:			
20X4 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	30,000	6,000	36,000
20X5 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	33,200	4,000	37,200
20X6 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	61,750	14,000	75,750

Үндсэн хөрөнгийн татварын суурийн тооцоо (мянган төгрөгөөр)

	Барилга	Тээврийн хэрэгсэл	Нийт дүн
Анхны өртөг:			
20X4 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	50,000	10,000	60,000
20X5 онд худалдан авсан хөрөнгийн дүн	6,000	-	6,000
20X5 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<u>56,000</u>	<u>10,000</u>	<u>66,000</u>
20X6 онд худалдан авсан хөрөнгийн дүн	-	15,000	15,000
20X6 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<u>56,000</u>	<u>25,000</u>	<u>81,000</u>
Хуримтлагдсан элэгдэл:			
20X4 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	40,000	5,000	45,000
20X5 оны элэгдэл	5,600	2,500	8,100
20X5 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<u>45,600</u>	<u>7,500</u>	<u>53,100</u>
20X6 оны элэгдэл	5,600	6,250	11,850
20X6 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<u>51,200</u>	<u>13,750</u>	<u>64,950</u>
Дансны үнэ:			
20X4 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,000	5,000	15,000
20X5 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	10,400	2,500	12,900

	Барилга	Тээврийн хэрэгсэл	Нийт дүн
20X6 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	4,800	11,250	16,050
20X4 оны 12-р сарын 31-ний хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр, хойшлогдсон татварын зардлын тооцоо (мянган төгрөгөөр)			
	Дансны үнэ	Татварын суурь	Түр зөрүү
Авлага	500	500	-
Бараа материал	2,000	2,000	-
Судалгаа, хөгжүүлэлтийн зардал	500	-	500
Хөрөнгө оруулалт	33,000	33,000	-
Үндсэн хөрөнгө	36,000	15,000	21,000
Хөрөнгийн нийт дүн	<u>72,000</u>	<u>50,500</u>	<u>21,500</u>
Дансны өглөг	500	500	-
ААНОАТ-ын өглөг	3,000	3,000	-
ХТӨТ	8,600	8,600	-
Урт хугацаат зээл	20,000	20,000	-
Өр төлбөрийн нийт дүн	<u>32,100</u>	<u>32,100</u>	<u>-</u>
Хувь нийлүүлсэн хөрөнгө	5,000	5,000	
Хуримтлагдсан ашиг	34,900	13,400	
Эздийн өмчийн дүн	<u>39,900</u>	<u>18,400</u>	
Өр төлбөр, эздийн өмчийн нийт дүн	<u>72,000</u>	<u>50,500</u>	
Түр зөрүү			<u>21,500</u>
Хойшлогдсон татварын өр төлбөр (40%)			8,600
Хойшлогдсон татварын хөрөнгө			-
Хойшлогдсон татварын өр төлбөр (цэвэр дүн)			<u>8,600</u>
20X5 оны 12-р сарын 31-ний хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр, хойшлогдсон татварын зардлын тооцоо (мянган төгрөгөөр)			
	Дансны үнэ	Татварын суурь	Түр зөрүү
Авлага	500	500	-
Бараа материал	2,000	2,000	-
Судалгаа, хөгжүүлэлтийн зардал	250	-	250
Хөрөнгө оруулалт	33,000	33,000	-
Үндсэн хөрөнгө	37,200	12,900	24,300
Хөрөнгийн нийт дүн	<u>72,950</u>	<u>48,400</u>	<u>24,550</u>
Дансны өглөг	500	500	-
Эрүүл мэндийн халамжийн хөтөлбөрт байгуулсан нөөц	2,000		(2,000)
Бусад өр төлбөр (Торгуулийн өглөг)	700	700	-
ААНОАТ-ын өглөг	3,570	3,570	-
ХТӨТ	9,020	9,020	-
Урт хугацаат зээл	12,475	12,475	-
Өр төлбөрийн нийт дүн	<u>28,265</u>	<u>26,265</u>	<u>(2,000)</u>
Хувь нийлүүлсэн хөрөнгө	5,000	5,000	
Хуримтлагдсан ашиг	39,685	17,135	
Эздийн өмчийн дүн	<u>44,685</u>	<u>22,135</u>	
Өр төлбөр, эздийн өмчийн нийт дүн	<u>72,950</u>	<u>48,400</u>	
Түр зөрүү			<u>22,550</u>
Хойшлогдсон татварын өр төлбөр (40%)			9,820
Хойшлогдсон татварын хөрөнгө (40%)			(800)
Хойшлогдсон татварын өр төлбөр (цэвэр дүн)			<u>9,020</u>
Хасах нь: Хойшлогдсон татварын өр төлбөрийн эхний үлдэгдэл			(8,600)
Түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон татварын зардал			<u>420</u>

Хүснэгт 1. ТҮР ЗӨРҮҮГ ТООЦООЛОХ ХУРААНГУЙ ХҮСНЭГТ

		Дансны үнэ		Татварын суурь		Түр зөрүү		Тайлант үеийн өөрчлөлт	Зөрүүгийн төрөл	
#	Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		Татвар ногдох түр зөрүү	Хасагдах түр зөрүү
		(1)	(2)	(3)	(4)	(5)=(1)-(3)	(6)=(2)-(4)			
1	Авлага	500	500	500	500	-	-	-		
2	Бараа материал	2,000	2,000	2,000	2,000	-	-	-		
3	Судалгаа, хөгжүүлэлтийн зардал	500	250			500	250	(250)	250	
4	Хөрөнгө оруулалт	33,000	33,000	33,000	33,000	-	-	-	-	
5	Үндсэн хөрөнгө	36,000	37,200	15,000	12,900	21,000	24,300	3,300	24,300	
12	Хөрөнгийн нийт дүн	72,000	72,950	50,500	48,400	21,500	24,550	3,050		
13	Дансны өглөг	500	500	500	500	-	-	-		
14	Эрүүл мэндийн халамжийн хөтөлбөрт байгуулсан нөөц	-	2,000	-	-	-	2,000	2,000		2,000
15	Бусад өр төлбөр	-	700	-	700	-	-	-		
15	ААНОАТ-ын өглөг	3,000	3,570	3,000	2,359					
16	ХТӨТ	8,600	9,020	8,600	19,845					
17	Урт хугацаат зээл	20,000	12,475	20,000	12,475	-	-	-		
20	Өр төлбөрийн нийт дүн	32,100	28,265	32,100	28,265	-	2,000	2,000		
21	Хувь нийлүүлсэн хөрөнгө	5,000	5,000	5,000	5,000					
22	Хуримтлагдсан ашиг	34,900	39,685	13,400	17,135					
29	Эздийн өмчийн дүн	39,900	44,685	18,400	22,135					
30	Өр төлбөр, эздийн өмчийн нийт дүн	72,000	72,950	50,500	48,400					
	Түр зөрүүгийн нийт дүн								24,550	2,000

Түр зөрүүг орлогын тайлангийн үзүүлэлтээр тооцоолбол:

Хөрөнгийн хувьд үүссэн түр зөрүү

Татварын зорилгоор байгуулсан элэгдэл	8,100
Хасах нь: Санхүүгийн тайлангийн элэгдлийн зардал	4,800
Хасах нь: ТНО-оос хасагдах зардалд орсон боловч санхүүгийн тайланд хөрөнгөөр толилуулсан дүнгээс орлогын тайланд зардалд шилжүүлсэн дүн	250
Тайлант хугацааны түр зөрүү	<u>3,050</u>

Өр төлбөрийн хувьд үүссэн түр зөрүү

Нэмж байгуулсан нөөц	2,000
Тайлант хугацааны түр зөрүү	<u>2,000</u>

**САНХҮҮГИЙН БОЛОН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАНГИЙН
ҮЗҮҮЛЭЛТ ХООРОНДЫН ЗӨРҮҮГ ЗОХИЦУУЛАХ ТАЙЛАН**

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

	Үзүүлэлт	Мөр	Дүн
	Санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийн дүн	1	8,775,000
А БАЙНГЫН ЗӨРҮҮГЭЭР ЗОХИЦУУЛАГДАХ ДҮН			
1	Байнгын зөрүүгийн нэмэгдүүлэх дүн (мөр 3+4)	2	1,200,000
	Албан татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	3	1,200,000
	Бусад байнгын зөрүүгийн нэмэгдүүлэх дүн	4	
2	Байнгын зөрүүгийн бууруулах дүн (мөр 6+7+8)	5	-
	Татвараас чөлөөлөгдөх орлогын дүн	6	
	Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлогын дүн	7	
	Бусад байнгын зөрүүгийн бууруулах дүн	8	
	БАЙНГЫН ЗӨРҮҮГЭЭР ЗОХИЦУУЛАГДСАН ДҮН (мөр 1+2-5)	9	9,975,000
Б ТҮР ЗӨРҮҮГЭЭР ЗОХИЦУУЛАГДАХ ДҮН			
	Хөрөнгөтэй холбоотойгоор тайлант үед үүссэн хасагдах түр зөрүү ба (татвар ногдох түр зөрүү)	10	(3,050,000)
	Өр төлбөртэй холбоотойгоор тайлант үед үүссэн хасагдах түр зөрүү ба (татвар ногдох түр зөрүү)	11	2,000,000
	Бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн татвар ногдох түр зөрүүг (нэмэгдүүлэх) бууруулах дүн ба хасагдах түр зөрүүг нэмэгдүүлэх (бууруулах) дүн	12	-
	ТҮР ЗӨРҮҮГЭЭР ЗОХИЦУУЛАГДСАН ДҮН (мөр 9+10+11+12)	13	8,925,000
В ТАТВАРЫН ТАЙЛАНГААРХ АЛДАГДЛЫН ҮЛДЭГДЛИЙН ТООЦОО			
	Өмнөх жилүүдийн алдагдлын эхний үлдэгдэл	14	
	Ирээдүйд нөхөгдөхөөр хүлээгдэж буй тайлант хугацаанд шинээр үүссэн алдагдлын дүн	15	
	Тайлант хугацаанд урьд жилүүдийн алдагдлаас шилжүүлэн тооцсон дүн	16	
	Алдагдлыг (буцаах) эсвэл нэмэгдүүлэх залруулга	17	
	Татварын тайлангаарх өмнөх жилүүдийн алдагдлын эцсийн үлдэгдэл (мөр 14+15-16+17)	18	-
Г ТАЙЛАНТ ҮЕИЙН ТАТВАРЫН ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ			
	Байнгын болон түр зөрүүгээр зохицуулагдсан татвар ногдуулах орлого (мөр 13)	19	8,925,000
	Сайн дурын даатгалын хураамжийн хэтрэлт	20	
	Шилжүүлэх алдагдлын дүн (мөр 14)	21	-
	Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын дүн (мөр 19+20-21)	22	8,925,000
	Ногдуулсан татвар (мөр 23*ААНОАТ-ын хуульд заасан татварын хувь хэмжээ)	24	3,570,000
	Хөнгөлөгдөх татварын дүн	25	
	Тусгай хувь хэмжээгээр төлбөл зохих татварын дүн	26	
	Төлөх татвараас хасч тооцуулаагүй гадаад улсад төлсөн татвар	26	
	Тайлант үеийн татварын зардал (мөр 23-24+25+26)	27	3,570,000
Д ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ӨР ТӨЛБӨРИЙН ТООЦООЛОЛ			
	Хойшлогдсон татварын өр төлбөрийн эхний үлдэгдэл	28	8,600,000
	Татварын хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас хойшлогдсон татварын өр төлбөрийг нэмэгдүүлэх (бууруулах) залруулга	29	-
	Хойшлогдсон татварын өр төлбөрийн эцсийн үлдэгдэл (Татвар ногдох түр зөрүүгийн дүн*Татварын дундаж хувь хэмжээ)	30	9,820,000
	Бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн хойшлогдсон татварын өр төлбөрийн дүн (буцаалт)	31	-
	Татвар ногдуулах түр зөрүүтэй холбоотой тайлант хугацаанд хүлээн зөвшөөрөх хойшлогдсон татварын зардал (орлого) (мөр 30-31-29-28)	32	1,220,000
Е ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ХӨРӨНГИЙН ТООЦООЛОЛ			
	Хойшлогдсон татварын хөрөнгийн эхний үлдэгдэл	33	-
	Татварын хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас хойшлогдсон татварын хөрөнгийг нэмэгдүүлэх (бууруулах) залруулга	34	-
	Хойшлогдсон татварын хөрөнгийн тооцоолсон эцсийн үлдэгдэл (Хасагдах түр зөрүүгийн дүн*Татварын дундаж хувь хэмжээ)	35	800,000

	Нөхөгдөх боломжгүй хойшлогдсон татварын хөрөнгийн дүн	36	
	Татварын тайлангаарх өмнөх жилүүдийн алдагдлын эцсийн үлдэгдлээс тооцсон хойшлогдсон татварын хөрөнгийн дүн (Мөр 18 * Татварын дундаж хувь хэмжээ)	37	
	Хойшлогдсон татварын хөрөнгийн эцсийн үлдэгдэл (мөр 35-36+37)	38	800,000
	Бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн хойшлогдсон татварын хөрөнгийн дүн (буцаалт)	39	
	Хасагдах түр зөрүүтэй холбоотой тайлант хугацаанд хүлээн зөвшөөрөх хойшлогдсон татварын зардал, (орлого) (мөр 33+34+39-38)	40	(800,000)

Ё ТАТВАРЫН ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ

	Орлогын дэлгэрэнгүй тайлан дахь татварын зардлын нийт дүн (мөр 42+43+44)	41	3,990,000
	Үүнээс: Тайлант үеийн татварын зардал (мөр 26)	42	3,570,000
	Түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон татварын зардал (орлого) (мөр 32+40)	43	420,000
	Татварын хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас үүссэн хойшлогдсон татварын зардал (орлого) (мөр 29-34)	44	

20Х6 оны 12-р сарын 31-ний хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр, хойшлогдсон татварын зардлын тооцоо (мянган төгрөгөөр)

	Дансны үнэ	Татварын суурь	Түр зөрүү
Авлага	500	500	-
Бараа материал	2,000	2,000	-
Хөрөнгө оруулалт	33,000	33,000	-
Үндсэн хөрөнгө	75,750	16,050	59,700
Хөрөнгийн нийт дүн	<u>111,250</u>	<u>51,550</u>	<u>59,700</u>
Дансны өглөг	500	500	-
Эрүүл мэндийн халамжийн хөтөлбөрт байгуулсан нөөц	3,000	-	(3,000)
Бусад өр төлбөр (Торгуулийн өглөг)	700	700	-
ААНОАТ-ын өглөг	2,359	2,359	-
ХТӨТ	19,845	19,845	-
Урт хугацаат зээл	12,805	12,805	-
Өр төлбөрийн нийт дүн	<u>39,209</u>	<u>36,209</u>	<u>(3,000)</u>
Хувь нийлүүлсэн хөрөнгө	5,000	5,000	
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19,637	-	
Хуримтлагдсан ашиг	47,404	10,341	
Эздийн өмчийн дүн	<u>72,041</u>	<u>15,341</u>	
Өр төлбөр, эздийн өмчийн нийт дүн	<u>111,250</u>	<u>51,550</u>	
Түр зөрүү			<u>56,700</u>
Хойшлогдсон татварын өр төлбөр (35%)			20,895
Хойшлогдсон татварын хөрөнгө (35%)			(1,050)
Хойшлогдсон татварын өр төлбөр (цэвэр дүн)			<u>19,845</u>
Хасах нь: Хойшлогдсон татварын өр төлбөрийн эхний үлдэгдэл			(9,020)
Татварын хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас эхний үлдэгдлийг нэмэгдүүлэх (бууруулах) залруулга			1,127
Хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой хойшлогдсон татвар			(11,130)
Түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон татварын зардал			<u>822</u>

20Х6 оны Түр зөрүүг тооцоолох ажлын хүснэгт (мянган төгрөгөөр)

#	Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлт	Дансны үнэ		Татварын суурь		Түр зөрүү		Тайлант үеийн өөрчлөлт	Зөрүүгийн төрөл	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл		Татвар ногдох түр зөрүү	Хасагдах түр зөрүү
		(1)	(2)	(3)	(4)	(5)=(1)-(3)	(6)=(2)-(4)		(8)	(9)
1	Авлага	500	500	500	500	-	-	-		
2	Бараа материал	2,000	2,000	2,000	2,000	-	-	-		
3	Судалгаа, хөгжүүлэлтийн зардал	250				250	-	(250)		
4	Хөрөнгө оруулалт	33,000	33,000	33,000	33,000	-	-	-		
5	Үндсэн хөрөнгө	37,200	75,750	12,900	16,050	24,300	59,700	35,400	59,700	
						-	-	-		
12	Хөрөнгийн нийт дүн	72,950	111,250	48,400	51,550	24,550	59,700	35,150		
13	Дансны өглөг	500	500	500	500	-	-	-		
14	Эрүүл мэндийн халамжийн хөтөлбөрт байгуулсан нөөц	2,000	3,000			2,000	3,000	1,000		3,000
15	Бусад өр төлбөр	700	700	700	700	-	-	-		
15	ААНОАТ-ын өглөг	3,570	2,359	3,570	2,359					
16	ХТӨТ	9,020	19,845	9,020	19,845					
17	Урт хугацаат зээл	12,475	12,805	12,475	12,805	-	-	-		
						-	-			
20	Өр төлбөрийн нийт дүн	28,265	39,209	26,265	36,209	2,000	3,000	1,000		
21	Хувь нийлүүлсэн хөрөнгө	5,000	5,000	5,000	5,000					
22	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		19,637							
23	Хуримтлагдсан ашиг	39,685	47,404	17,135	10,341					
29	Эздийн өмчийн дүн	44,685	72,041	22,135	15,341					
30	Өр төлбөр, эздийн өмчийн нийт дүн	72,950	111,250	48,400	51,550					
Түр зөрүүгийн нийт дүн									59,700	3,000

Түр зөрүүг орлогын тайлангийн үзүүлэлтээр тооцоолбол:

Хөрөнгийн хувьд үүссэн түр зөрүү

Татварын зорилгоор байгуулсан элэгдэл	11,850
Хасах нь: Санхүүгийн тайлангийн элэгдлийн зардал	8,250
Хасах нь: ТНО-оос хасагдах зардалд орсон боловч санхүүгийн тайланд хөрөнгөөр толилуулсан дүнгээс орлогын тайланд зардалд шилжүүлсэн дүн	250
Бусад дэлгэрэнгүй орлогыг нэмэгдүүлсэн түр зөрүүгийн дүн	31,800
Тайлант хугацааны түр зөрүү	35,150
Өр төлбөрийн хувьд үүссэн түр зөрүү	
Нэмж байгуулсан нөөц	1,000
Тайлант хугацааны түр зөрүү	1,000

**САНХҮҮГИЙН БОЛОН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТАЙЛАНГИЙН
ҮЗҮҮЛЭЛТ ХООРОНДЫН ЗӨРҮҮГ ЗОХИЦУУЛАХ ТАЙЛАН**

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

	Үзүүлэлт	Мөр	Дүн
	Санхүүгийн тайлангийн татварын өмнөх ашгийн дүн	1	8,740,000
А БАЙНГЫН ЗӨРҮҮГЭЭР ЗОХИЦУУЛАГДАХ ДҮН			
1	Байнгын зөрүүгийн нэмэгдүүлэх дүн (мөр 3+4)	2	350,000
	Албан татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	3	350,000
	Бусад байнгын зөрүүгийн нэмэгдүүлэх дүн	4	
2	Байнгын зөрүүгийн бууруулах дүн (мөр 6+7+8)	5	-
	Татвараас чөлөөлөгдөх орлогын дүн	6	
	Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлогын дүн	7	
	Бусад байнгын зөрүүгийн бууруулах дүн	8	
	БАЙНГЫН ЗӨРҮҮГЭЭР ЗОХИЦУУЛАГДСАН ДҮН (мөр 1+2-5)	9	9,090,000
Б ТҮР ЗӨРҮҮГЭЭР ЗОХИЦУУЛАГДАХ ДҮН			
	Хөрөнгөтэй холбоотойгоор тайлант үед үүссэн хасагдах түр зөрүү ба (татвар ногдох түр зөрүү)	10	(35,150,000)
	Өр төлбөртэй холбоотойгоор тайлант үед үүссэн хасагдах түр зөрүү ба (татвар ногдох түр зөрүү)	11	1,000,000
	Бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн татвар ногдох түр зөрүүг (нэмэгдүүлэх) бууруулах дүн ба хасагдах түр зөрүүг нэмэгдүүлэх (бууруулах) дүн	12	31,800,000
	ТҮР ЗӨРҮҮГЭЭР ЗОХИЦУУЛАГДСАН ДҮН (мөр 9+10+11+12)	13	6,740,000
В ТАТВАРЫН ТАЙЛАНГААРХ АЛДАГДЛЫН ҮЛДЭГДЛИЙН ТООЦОО			
	Өмнөх жилүүдийн алдагдлын эхний үлдэгдэл	14	
	Ирээдүйд нөхөгдөхөөр хүлээгдэж буй тайлант хугацаанд шинээр үүссэн алдагдлын дүн	15	
	Тайлант хугацаанд урьд жилүүдийн алдагдлаас шилжүүлэн тооцсон дүн	16	
	Алдагдлыг (буцаах) эсвэл нэмэгдүүлэх залруулга	17	
	Татварын тайлангаарх өмнөх жилүүдийн алдагдлын эцсийн үлдэгдэл (мөр 14+15-16+17)	18	-
Г ТАЙЛАНТ ҮЕИЙН ТАТВАРЫН ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ			
	Байнгын болон түр зөрүүгээр зохицуулагдсан татвар ногдуулах орлого (мөр 13)	19	6,740,000
	Сайн дурын даатгалын хураамжийн хэтрэлт	20	
	Шилжүүлэх алдагдлын дүн (мөр 16)	21	-
	Нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах орлогын дүн (мөр 20+21-22)	22	6,740,000
	Ногдуулсан татвар (мөр 23*ААНОАТ-ын хуульд заасан татварын хувь хэмжээ)	23	2,359,000
	Хөнгөлөгдөх татварын дүн	24	
	Тусгай хувь хэмжээгээр төлбөл зохих татварын дүн	25	
	Төлөх татвараас хасч тооцуулаагүй гадаад улсад төлсөн татвар	26	
	Тайлант үеийн татварын зардал (мөр 23-24+25+26)	27	2,359,000
Д ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ӨР ТӨЛБӨРИЙН ТООЦООЛОЛ			
	Хойшлогдсон татварын өр төлбөрийн эхний үлдэгдэл	28	9,820,000
	Татварын хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас хойшлогдсон татварын өр төлбөрийг нэмэгдүүлэх (бууруулах) залруулга	29	(1,227,500)
	Хойшлогдсон татварын өр төлбөрийн эцсийн үлдэгдэл (Татвар ногдох түр зөрүүгийн дүн*Татварын дундаж хувь хэмжээ)	30	20,895,000
	Бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн хойшлогдсон татварын өр төлбөрийн дүн (буцаалт)	31	11,130,000
	Татвар ногдуулах түр зөрүүтэй холбоотой тайлант хугацаанд хүлээн зөвшөөрөх хойшлогдсон татварын зардал, (орлого) (мөр 30-31-29-28)	32	1,172,500
Е ХОЙШЛОГДСОН ТАТВАРЫН ХӨРӨНГИЙН ТООЦООЛОЛ			
	Хойшлогдсон татварын хөрөнгийн эхний үлдэгдэл	33	800,000
	Татварын хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас хойшлогдсон татварын хөрөнгийг нэмэгдүүлэх (бууруулах) залруулга	34	(100,000)

Хойшлогдсон татварын хөрөнгийн тооцоолсон эцсийн үлдэгдэл (Хасагдах түр зөрүүгийн дүн*Татварын дундаж хувь хэмжээ)	35	1,050,000
Нөхөгдөх боломжгүй хойшлогдсон татварын хөрөнгийн дүн	36	
Татварын тайлангаарх өмнөх жилүүдийн алдагдлын эцсийн үлдэгдлээс тооцсон хойшлогдсон татварын хөрөнгийн дүн (Мөр 19 * Татварын дундаж хувь хэмжээ)	37	
Хойшлогдсон татварын хөрөнгийн эцсийн үлдэгдэл (мөр 36-37+38)	38	1,050,000
Бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн хойшлогдсон татварын хөрөнгийн дүн (буцаалт)	39	
Хасагдах түр зөрүүтэй холбоотой тайлант хугацаанд хүлээн зөвшөөрөх хойшлогдсон татварын зардал, (орлого) (мөр 33+34+39-38)	40	(350,000)

Ё ТАТВАРЫН ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ

Орлогын дэлгэрэнгүй тайлан дахь татварын зардлын нийт дүн (мөр 42+43+44)	41	2,054,000
Үүнээс: Тайлант үеийн татварын зардал (мөр 28)	42	2,359,000
Түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон татварын зардал (орлого) (мөр 32+40)	43	822,500
Татварын хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас үүссэн хойшлогдсон татварын зардал (орлого) (мөр 29-34)	44	(1,127,500)

Хойшлогдсон татвартай холбоотойгоор 20Х6 оны 12-р сарын 31-ний санхүүгийн тайланд дараах тодруулгыг оруулна.

Татварын зардлын бүрэлдэхүүн

	20Х5 он	20Х6 он
Тайлант үеийн татварын зардал	3,570,000	2,359,000
Түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон татварын зардал (орлого)	420,000	822,500
Татварын хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас үүссэн хойшлогдсон татварын зардал (орлого)	-	(1,127,000)
Татварын зардлын дүн	3,990,000	2,054,000

Бусад дэлгэрэнгүй орлогод хамаарах орлогын албан татвар

	20Х5 он	20Х6 он
Барилгын дахин үнэлгээнд хамаарах хойшлогдсон татвар	-	11,130,000

20Х6 онд 557,000₮-ийн хойшлогдсон татварыг хуримтлагдсан ашгаас хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансруу хаасан. Энэ дүн нь барилгын элэгдлийн бодит зардал ба өртгөөс тооцоолсон эквивалент элэгдлийн зардлын зөрүү юм.

Татварын зардал ба татварын өмнөх ашгийн хоорондын холбоо хамаарал

	20Х5 он	20Х6 он
Татварын өмнөх ашиг	8,775,000	8,740,000
35%-иар тооцоолсон татвар (20Х5 онд 40%-иар)	3,510,000	3,059,000
Албан татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал:		
Хандив тусламжийн зардал	200,000	122,000
Торгууль	280,000	-
Татварын хувь хэмжээний өөрчлөлтийн улмаас хойшлогдсон татварыг нэмэгдүүлэх (бууруулах) залруулга	-	(1,127,000)
Татварын зардлын дүн	3,990,000	2,054,000

Татварын хувь хэмжээнд өөрчлөлт орсон тухай тайлбар

Засгийн газрын тогтоолоор татварын хувь хэмжээ 20Х5 онд 40% байсныг 20Х6 онд 35% болгож бууруулсан.

Түр зөрүүтэй холбоотойгоор хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татвар

	20Х5 он	20Х6 он
Татварын зорилгоор байгуулсан элэгдэл	9,720,000	10,322,000
Эрүүл мэндийн халамжийн хөтөлбөрт байгуулсан нөөцийг төлөгдсөн үед нь татвар ногдох орлогоос хасна	(800,000)	(1,050,000)
Өмнөх тайлант жилд татварын тайланд хасагдах зардалд оруулан тайлагнасан судалгаа хөгжүүлэлтийн зардал	100,000	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл ба дахин үнэлгээ	-	10,573,000
Хойшлогдсон татварын өр төлбөр	9,020,000	19,845,000

Жишээ 9 - Бизнесийн нэгдэл

Дараах жишээ нь НББОУС 12 “Орлогын албан татвар”-т орсон хавсралт жишээ болно. Татварын хууль тогтоомжийн онцлогоос хамаарч жишээнд дурдагдсан зарим зүйлс Монгол Улсын хувьд ялгаатай байж болно.

20X5 оны 1-р сарын 1-нд А компани Б компанийн бүх хувьцааг 600,000 төгрөгөөр худалдан авсан. Худалдан авалтын өдөр А компанийн оршин буй улсын татварын хууль тогтоомжоор А компаниас Б компанид оруулсан хөрөнгө оруулалтын татварын суурийг 600,000 төгрөг гэж тодорхойлсон. Гүүдвилийн дансны үнийн бууралтыг татварын зорилгоор хасагдах зардал оруулахгүй. А компанийн оршин буй улсын татварын хууль тогтоомжинд зааснаар орлогын албан татварын хувь хэмжээ 30% бол харин Б компанийн оршин буй улсын татварын хууль тогтоомжинд зааснаар орлогын албан татварын хувь хэмжээ 40%.

Доорх хүснэгтэнд бизнесийн нэгдлээр А компанийн худалдан авсан тодорхойлогдох хөрөнгө, тооцоолох өр төлбөрийн бодит үнэ цэнийг харуулахын зэрэгцээ Б компанийн оршин буй улсын татварын хууль тогтоомжийн дагуу тооцоолсон татварын суурь, түүнийг ашиглан гаргасан түр зөрүүг харууллаа.

	Худалдан авалтаар хүлээн зөвшөөрсөн дүн	Татварын суурь	Түр зөрүү
Үндсэн хөрөнгө	270,000	155,000	115,000
Дансны авлага	210,000	210,000	-
Бараа материал	174,000	124,000	50,000
Тэтгэвэрийн төлөвлөгөөтэй холбоотой өр төлбөр	(30,000)	-	(30,000)
Дансны өглөг	(120,000)	(120,000)	-
Тодорхойлогдох хөрөнгө, тооцоолсон өр төлбөрийн дүн (хойшлогдсон татварыг оруулаагүй)	<u>504,000</u>	<u>369,000</u>	<u>135,000</u>

Тэтгэвэрийн төлөвлөгөөтэй холбоотой өр төлбөрөөс үүсгэсэн хойшлогдсон татварын хөрөнгөөс үндсэн хөрөнгө, бараа материалтай холбоотой үүсгэсэн хойшлогдсон татварын өр төлбөрийг хасаж цэвэршүүлсэн дүнгээр тайлагнасан.

Б компанийн оршин буй улсын татварын хууль тогтоомжийн дагуу гүүдвилийн өртгийн бууралтыг хасагдах зардалд оруулахгүй. Иймээс Б компанийн оршин буй улсын татварын хууль тогтоомжийн дагуу гүүдвилийн татварын суурь тэг болно. Гэхдээ НББОУС 12-ын дагуу А компани Б компанийн оршин буй улсын татварын хууль тогтоомжинд заасан гүүдвилтэй холбоотой татвар ногдуулах түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон татварын өр төлбөр хүлээн зөвшөөрч, бүртгээгүй.

А компанийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Б компанид оруулсан хөрөнгө оруулалтын дансны үнийг дараах байдлаар тооцоолж харуулсан. Үүнд:

Тодорхойлогдох хөрөнгө, тооцоолсон өр төлбөрийн цэвэр дүн (хойшлогдсон татварыг оруулаагүй)	504,000
Хойшлогдсон татварын өр төлбөр (135,000*40%)	(54,000)
Тодорхойлогдох хөрөнгө, тооцоолсон өр төлбөрийн бодит үнэ цэн	<u>450,000</u>
Гүүдвил	150,000
Дансны үнэ	<u>600,000</u>

Худалдан авалтын өдөр А компанийн оршин буй улсын татварын хууль тогтоомжийн дагуу А компаниас Б компанид оруулсан хөрөнгө оруулалтын татварын суурийг 600,000 төгрөг гэж үнэлсэн тул хөрөнгө оруулалттай холбоотойгоор түр зөрүү үүсэхгүй.

20X5 онд Б компанийн эздийн өмч дараах байдлаар өөрчлөгдсөн. Энэ тооцоололд бизнесийн нэгдлийн үр дүнд хийгдсэн бодит үнэ цэнийн тохируулгыг оруулсан. Үүнд:

20X5 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	450,000
20X5 онд хуримтлуулсан ашиг (150,000₮-ийн цэвэр ашгаас 80,000₮-ийн ногдол ашгийг хассан)	70,000
20X5 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	<u>520,000</u>

А компанийн авах 80,000 төгрөгийн ногдол ашигт ногдуулсан татварын өглөгийг А компани хүлээн зөвшөөрч, бүртгэсэн.

20X5 оны 12-р сарын 31-ний байдлаар А компаниас Б компанид оруулсан хөрөнгө оруулалтын дансны үнийг ногдол ашгийн авлагыг оруулалгүй дараах байдлаар гаргасан. Үүнд:

Б компанийн цэвэр хөрөнгийн дүн	520,000
Гүүдвил	150,000
Дансны үнэ	<u>670,000</u>

А компанийн хөрөнгө оруулалттай холбоотой түр зөрүү 70,000 төгрөг. Энэ дүн нь худалдан авалтын өдрөөс хойш хуримтлагдсан цэвэр ашгийн дүнтэй тэнцэнэ.

Хэрэв А компани ойрын ирээдүйд уг хөрөнгө оруулалтыг бусдад худалдан борлуулахгүй бөгөөд Б компани ойрын ирээдүйд энэ хуримтлагдсан ашгийг хуваарилах төлөвлөгөөгүй гэж А компани тогтоосон бол А компаниас Б компанид оруулсан хөрөнгө оруулалттай холбоотойгоор хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрч, бүртгэхгүй. Ойрын ирээдүйд хараат компанийн ашгийг хуваарилахгүй байх хэлцлийн улмаас хараат компанид оруулсан хөрөнгө оруулалтанд хамаарах НББОУС 12-ын заалтын дагуу ийнхүү хүлээн зөвшөөрөөгүй. Иймээс хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татвартай холбоотой түр зөрүү болох 70,000 төгрөгийг тодруулгын хэсэгт дурдана.

Хэрэв А компани Б компанид оруулсан хөрөнгө оруулалтаа худалдан борлуулахаар зэхэж байгаа эсхүл Б компани ойрын ирээдүйд хуримтлагдсан ашгаа хуваарилах төлөвлөгөөтэй гэж таамаглаж байгаа бол А компани нөхөгдөх түр зөрүүгийн хэмжээгээр хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. А компанийн хөрөнгө оруулалтынхаа дансны үнийг нөхөгдөхөөр таамаглаж буй хугацааг харгалзан татварын хувь хэмжээг тогтооно. А компани хойшлогдсон татварыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх ба энэ нь бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэсэн гадаад валютын хөрвүүлэлтийн ханшийн зөрүүгийн үлдэгдлээс хэтрэхгүй. Түүнчлэн А компани дараах зүйлсийг тусад нь тодруулна. Үүнд:

а) Бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын дүн;

б) Ойрын ирээдүйд нөхөгдөх боломжгүй гэж таамаглаад улмаар хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр хүлээн зөвшөөрөөгүй түр зөрүүгийн дүн.

Жишээ 10 - Нийлмэл санхүүгийн хэрэглүүр

Дараах жишээ нь НББОУС 12 “Орлогын албан татвар”-т орсон хавсралт жишээ болно. Татварын хууль тогтоомжийн онцлогоос хамаарч жишээнд дурдагдсан зарим зүйлс Монгол Улсын хувьд ялгаатай байж болно.

Аж ахуйн нэгж хүүгүй, хөрвөх нөхцөлтэй, 1,000,000 төгрөгийн зээлийг 20X4 оны 12-р сарын 31-нд авсан ба уг зээлийг 20X8 оны 1-р сарын 1-нд эргүүлэн төлнө. НББОУС 32 -ын дагуу аж ахуйн нэгж уг санхүүгийн хэрэгслийг өр төлбөр ба өмчийн дансанд салгаж бүртгэсэн. Ингэхдээ өр төлбөрт 751,000, эздийн өмчид 249,000 төгрөгийг хуваарилсан. Үүний дараа тухайн жилийн эхэнд энэ хэрэгслийн өр төлбөрийн хэсгээс 10%-ийн хүүгээр бодож, нуугдмал хүүг тооцоолон, хүүгийн зардалд хүлээн зөвшөөрч, бүртгэсэн. Татварын байгууллага аж ахуйн нэгжийн хөрвөх зээлийн өрийн хэсгээс тооцоолсон нуугдмал хүүг хасагдах зардалд оруулахыг зөвшөөрдөггүй. Татварын хувь хэмжээ 40%.

Өр төлбөртэй холбоотой түр зөрүү, түүнтэй холбоотой үүссэн хойшлогдсон татварын өр төлбөр, хойшлогдсон татварын зардал, орлогыг доор харуулав. Үүнд:

	Тайлант хугацаа			
	20X4 он	20X5 он	20X6 он	20X7 он
Өр төлбөрийн дансны үнэ	751,000	826,000	909,000	1,000,000
Татварын суурь	1,000,000	1,000,000	1,000,000	1,000,000
Татвар ногдуулах түр зөрүү	<u>249,000</u>	<u>174,000</u>	<u>91,000</u>	-
Хойшлогдсон татварын өр төлбөрийн эхний үлдэгдэл	-	100,000	70,000	37,000
Эздийн өмчид бүртгэсэн хойшлогдсон татвар	100,000	-	-	-
Хойшлогдсон татварын зардал (орлого)	-	(30,000)	(33,000)	(37,000)
Хойшлогдсон татварын өр төлбөрийн эцсийн үлдэгдэл	<u>100,000</u>	<u>70,000</u>	<u>37,000</u>	-

20X4 оны 12-р сарын 31-нд аж ахуйн нэгж хөрвөх өр төлбөрийн өмчийн хэсгийн анхны дансны үнийг тохируулах замаар хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрч, бүртгэсэн. Иймээс тухайн өдрөөр хүлээн зөвшөөрсөн дүнг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

Өр төлбөрийн хэсгийн дүн	751,000
Хойшлогдсон татварын өр төлбөр	100,000
Өмчийн хэсгийн дүн (249,000 - 100,000)	149,000

1,000,000

Энэхүү хойшлогдсон татварын өр төлбөртэй холбоотойгоор дараа дараагийн тайлант үеүдэд гарах өөрчлөлтийг татварын орлого, зардалд хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Иймээс аж ахуйн нэгжийн орлогын тайланд дараах зүйлсийг орлого, зардлаар толилуулна.

	Тайлант хугацаа			
	20X4 он	20X5 он	20X6 он	20X7 он
Хүүгийн зардал (нуугдмал хүү)	-	75,000	83,000	91,000
Хойшлогдсон татварын зардал (орлого)	-	(30,000)	(33,000)	(37,000)
	-	<u>45,000</u>	<u>50,000</u>	<u>54,000</u>